

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-31

**1.Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн
талаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар
хотын захирагчийн мэдээллийг сонсох** 3-31

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны
12 дугаар сарын 17-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны дарга Ч.Анар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 12 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Тасалсан: Ц.Баатархүү, Х.Булгантуяа, Б.Жаргалан.

**Нэг.Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаар нийслэлийн
Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Хоёрдугаар орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологийн газрын дарга П.Нэргүй, мөн газрын Дэд бүтэц, техник хяналтын хэлтсийн дарга Б.Түмэнбаяр, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн дарга Ч.Хувьзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Шижирмөнх байлцав.

Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологийн газрын Дэд бүтэц, техник хяналтын хэлтсийн дарга Б.Түмэнбаяр нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Р.Батболд, Ж.Золжаргал, С.Цэнгүүн, Ч.Анар нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Хоёрдугаар орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологийн газрын Дэд бүтэц, техник хяналтын хэлтсийн дарга Б.Түмэнбаяр, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн дарга Ч.Хувьзаяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ж.Золжаргал, Ч.Анар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаарх Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх Нийслэлийн Засаг даргын Нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологийн газрын Дэд бүтэц, техник хяналтын хэлтсийн дарга Б.Түмэнбаяр нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 39 минут үргэлжилж, 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

Ч.АНАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
15 цаг 12 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Анар: Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрэлдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг дуудъя. Чинбаатарын Анар, Ринчиндоржийн Батболд, Пүрэвжавын Ганзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүд өнөөдрийн ирцэд хүрэлцэн ирснээр өнөөдрийн хуралдааныг эхэлье. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Инновац, цахим хөгжлийн дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, дэд хорооны ирц 57.1 хувьтай бүрэлдсэн тул дэд хорооны

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал. Нэг хэлэлцэх асуудалтай.

Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу?

Саналтай гишүүд алга. Хэлэлцэх асуудалдаа оръё. Нийслэлийнхнийг оруулж ирэх үү дээ.

Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Нийслэлийн цахим шилжилтийн төслүүдийн талаар нийслэлээс Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч Түмэндалайн Даваадалай. Өөр ажлын хэсгээс ирсэн гишүүд хэн билээ? Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологийн газрын дарга Пүрэвдоржийн Нэргүй, Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төвийн дарга Чулуунхүүгийн Хувьзаяа нар хүрэлцэн ирсэн байна.

Танилцуулгаа эхлүүлэх үү? Даваадалай даргын микрофоныг өгье.

Т.Даваадалай: Эрхэм хүндэт Улсын Их Хурал дахь Инновац, цахим бодлогын дэд хорооны гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй мэдээлэл, технологийн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ болон ойрын зорилт. Зорилгыг товчхон танилцуулъя.

Нийслэл Улаанбаатар хотын гудамжинд тулгамдаж буй асуудал, үйлчилгээ, түүний чанар, хүртээмжийг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах Улаанбаатар хотын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан зогсоох, илрүүлэх замаар нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн аюулгүй, амар тайван орчныг хангахад бүрдүүлэхэд мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг ашиглах урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан НИТХ-аар батлуулахаар бэлтгэл ажлыг бас ханган ажиллаж байгаа.

Энэхүү танилцуулга нь өнгөрсөн жил хийсэн болон 2026 онд ямар ажил гүйцэтгэх талаар та бүхэндээ бас товчхон танилцуулгыг хийе. Мөн нийслэлийн 2026 оны төсвийн хэлэлцүүлэгтэй уялдуулаад 77 мянга гаруй иргэнээс санал авахад 1 дүгээр байранд иргэдээс, Улаанбаатар хотын иргэдээс гудамжны болон орчны камержуулалт хамгийн хэрэгтэй юм гэдэг иргэдээс хамгийн өндөр санал, асуулга ирснийг бас энд дурдах нь зүйтэй байх.

Бид 2025 онд нийслэлийн Теле камерын нэгдсэн төв болон нутгийн захиргааны байгууллагын дэргэд 9 дүүргийн Засаг даргын дэргэд Теле камерын хяналтын дэд төвийг байгуулж ажилласан. Мөн Улаанбаатар хотын 176 уулзвар гарц, авто замын иж бүрийг камержуулж, 10 төрлийн зөрчлийг хиймэл оюун ухаанд суурилсан систем ашиглан илрүүлэх ийм боломжтой болгож ажиллаад байж байгаа. Мөн тус системийг ашиглах эрх зүйн боломжийг бүрдүүлж Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг бас тус тус оруулсан.

Харин дэд төвүүдийн тухайд нэгдсэн төвтэй өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбож, дүрс бичлэг шууд үзэх, дүүрэг хороо мэдээллийг дамжуулах уялдаа холбоог сайжруулсан. Шуурхай штабуудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд шуурхай ажиллах боломжтой болгож ингэж төвлөрүүлж ажилласан байж байгаа.

Нийслэлийн Теле камерын нэгдсэн удирдлагын төвд авто замын хяналтын болон зөрчлийн камер 9 дүүргийн Теле камерын дэд хяналтын төвд холбогдож дүүргүүдэд байгаа нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь хувийн болон төрийн эзэмшлийн хяналтын камеруудыг мөн бас нэгтгээд байгаа. Нэгдсэн системд холбох ийм ажлууд хийгдэж байна. Ирэх жил энэхүү ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж программ хангамж, холболтуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэхээр төлөвлөж ажиллаж байна.

Ач холбогдлын хувьд болохоор Засгийн газрын 2024 оны 86 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, өнгөрсөн жилүүдэд хийгдсэн олон төрлийн үйлдвэрлэгчийн камер, системүүдийг нэгтгэх, нэгдсэн бодлого удирдлагаар хангах, нэгдсэн удирдлагын төвөөс дэд төв, дэд төвүүд хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бий болгоод интеграцилалыг үүсгэхээр мөн ажиллаж байна.

Мөн камер ашиглалтын хугацааг бүрэн хянаж, ашиглалтын зардлыг гүйцэтгэлээр ингээд санхүүжүүлэхээр мөн төлөвлөж байна. Дээрх үйл ажиллагаануудыг хангаснаар Улаанбаатар хотод дараах үр дүн гарна гэж төлөвлөж байна. Авто замын хөдөлгөөний эрчмийн тооллогын бодит цагийн горимд авто замын хөдөлгөөн хийгддэг болсон. Авто зам дээрх осол, саатлыг цаг алдалгүй мэддэг болсон. 7 дугаар сард зохих шугамын зөрчил 335860 гарсан бол

11 дүгээр сард 166425 болж 50.4 хувиар буурсан байна. 7 дугаар сард эгнээ, байрны зөрчил 4 сая 406 мянга гарч байсан бол 11 дүгээр сард 1 сая 846 мянга болж 58 хувиар бас буурсан байна.

Мөн энэ хэмжээгээр тухайн уулзваруудын нэвтрүүлэх чадвар бас тэр хэмжээгээрээ сайжирсан гэсэн үг. Хуурамч болон улсын бүртгэлгүй, дугааргүй тээврийн хэрэгслийг илрүүлэн хариуцлага тооцож бас мөн ажиллаж байна. 2025 оны 4 сараас эхлэн тусгай чиг үүргийн байгууллагуудад зам, тээврийн осол гэмт хэрэгтэй холбогдолтой нотлох баримтын болон хойшлуулшгүй ажиллагаанд системийг ашиглуулах зорилгоор хар тамхи, хулгай дээрэм гэх мэт 1088 хүсэлт ирүүлснээс 744-ийг нь яаралтай байдлаар баримтыг гарган өгч хүчний байгууллагуудтай бас хамтарч ажиллаж анхан болон дунд шатын баримт бичиг, мэдээллийг цаг алдалгүй бас олгосон байна.

Эцэст нь теле камерын нэгдсэн систем болон дэд хяналтын төвөөс мэдээллийг тусгай чиг үүргийн байгууллагад өөр өөрийн хуульд заасан эрх зүйн хүрээнд мэдээллийг авч үндсэн чиг үүргийн дагуу ашиглах нөхцөлийг бас бүрдүүлээд байгаагаараа бас өндөр ач холбогдолтой гэж үзэж байна.

Нийтийн тээврийн цахим системийн хувьд энэ хүрээнд бид нар төлбөр тооцооны болон тээврийн удирдлагын системийг хөгжүүлээд нийтийн тээврийн бодлогын газар 19 авто баазад нэвтрүүлж бусад төрийн байгууллагуудын системүүдтэй интеграци хийгээд байгаа. Мөн 1100 автобусанд жолоочийн хяналтын камер, урд замын хяналтын камер, зорчигч тоологч, алкоголь мэдрэгч карт болон QR код уншигч, агаарын чанарын мэдрэгч, жолоочийн компьютер, 4G роботоор гэх мэт төхөөрөмжүүдийг суурилуулан нэгдсэн байдлаар хянаж, мэдээллүүдийг авах боломжтой болгоод хөгжүүлэлтүүдийг цаашаа хийж ажиллаж байна.

Төлбөр тооцооны системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд гар утсаараа нийтийн тээврийн төлбөрийг төлөх UBCard аппликэйшн, шинэ төлбөрийн карт, иргэдэд үйлчлэх автомат машин буюу киоск болон бүх төрлийн банкны төлбөрийг унших боломжийг мөн бүрдүүлсэн. UBCard аппликэйшныг бид нар 4 удаагийн зорчилтыг 1000 төгрөгөөр хийхээр тэгээд автобусны парк шинэчлэлтэй уялдуулаад 2023, 2024 онд нийтийн тээврийн орлого 28, 31 тэрбум хүрч байсан бол өнөөдрийн байдлаар 2025 оны байдлаар нийтийн тээврийн орлого 65 тэрбумыг даваад буюу 220 гаруй хувьтай нийтийн тээврийн орлого 25 онд бүрдээд цаашаа ингээд явж байгаа.

Харин зорчигчийн хувьд болохоор бас 40-50 хувийн урсгал нийтийн тээвэр нэмэгдсэн гэсэн эерэг үзүүлэлтүүдийг бас UBCard аппликэйшн болон системүүд дээр сайжруулалт хийснээр гарч байгаа. Улаанбаатар карт, автобусны карт 1 удаагийн цаасан тасалбар, хөнгөлөлттэй зорчих карт зэрэг 5 төрлийн картыг бас UBCard-ын хувьд нэвтрүүлээд байгаа. Киоскийн хувьд киоскоор 1 удаагийн тасалбар авах, карт авах, цэнэглэх ийм боломжтой болгосон. Лед самбар зорчигчийн мэдээллийн самбараар зорчигчийг мэдээллийн самбарын тусламжтайгаар тухайн автобусны буудал дээр ирж буй чиглэлийн автобусны мэдээллийг харуулах ийм боломжтой болсон.

Хотын нийтийн тээврийн системийг орчин үеийн дэвшилтэт шийдлүүд дээр шинэчилснээр иргэдэд ая тухтай, төрд хяналттай, хариуцлагатай үйлчилгээ бий болгож, Хурдан системтэй холбогдсоноор зорчигчийн бүртгэл, төлбөр уян хатан

нөхцөл бүрдэж, хөнгөлөлттэй зорчиход ахмад настан болон тусгай хэрэгцээт иргэд, оюутан сурагчдад цахим картаар шууд үйлчлүүлэх бас боломжтой болж байгаа.

Жолооч, зорчигчдын зөрчлийн бүртгэл хийснээр нийтийн тээврийн соёл сайжирч бас осол, зөрчлөөс бас урьдчилан сэргийлэх боломжтой байж байгаа.

Түрүүний бас мэдээллүүдийг нэгтгэснээрээ бид нар 2026 онд бас нийтийн тээврийн салбарт бүрэн шинэчлэл хийж, нийтийн тээврийн хувийн болон улсын 5 өмчит автобус баазуудад KPI үйлчилгээ бас нэвтрүүлэхээр суурь судалгаа хийгдэж байгаа. Тэр суурь судалгааны KPI үзүүлэлт маань бас энэхүү нийтийн тээврийн салбарт шинэчлэл хийсэн карт болон түрүүний ярьсан анхан шатын мэдээлэл өгөх төхөөрөмжүүдээс KPI-ийн үндсэн үзүүлэлтүүд гарч ирэхээр бас холбогдож ажиллаж бас нийтийн тээврийн салбарын шинэчлэлийг 2026 онд бас уялдуулаад бас төлөвлөж байгааг бас дуулгахад таатай байна.

Нийтийн тээвэрт төвлөрөх боломжтой бодит орлогыг зорчигч тоолох системээр тооцож, нийтийн тээврийн чанар, хүртээмж сайжирснаар нийслэлийн төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлсэн түрүүн дурдсанаар. Цагдаагийн байгууллагуудын ажилтнууд нийтийн тээврээр хөнгөлөлттэй, хяналттай зорчих нөхцөл бүрдэв. Цагдаагийн албан хаагч нар нийтийн тээврээр ажлын үнэмлэхээ үзүүлээд үнэ төлбөргүй зорчдог байсан ба энэ нь ямар албан хаагч нийт хэдэн удаа зорчиж байгаа талаар мэдээлэл цугладаггүй байсан.

Ийм учраас бас нийт албан хаагчийн тоогоор сар бүр татаас өгдөг байсан. Одоо харин албан хаагч нарын нарийн зорчилтын тоон мэдээлэл дээр суурилуулан татаасыг бууруулах яг ямар албан хаагч хэдэн удаа зорчоод байна гэдэг мэдээллүүдийг бас тус бүрээр харах ийм боломжтой болж байгаа. Үүнээс гадна нээлттэй өгөгдлийн сан үүсгэж, судлаач, эрдэмтдэд нийтийн тээврийн дата, мэдээлэл дээр ажиллах боломжийг бас олгосноор замын хөдөлгөөн зорчих урсгалыг оновчтой төлөвлөх бас нөхцөлүүдийг бас бүрдүүлж байна.

Нийслэлийн төрийн байгууллага, бизнес эрхлэгчид, иргэдийн холбосон иргэдийн өдөр тутмын хэрэглээний аппликэйшнүүдийг нэг дор багтаасан дижитал платформыг нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд нэмэлт хөгжүүлэлт хийгдсээр байна. Өнөөдрийн байдлаар 195555 таталт хийгдэж нийт 170234 иргэн ашиглаж байна. Хагас коксожсон шахмал түлшийг Hotula аппликэйшнээр дамжуулан олгож байгааг бас та бүхэн мэдэж байгаа. Иргэд өөрт байгаа цэг, нөөц зэргийг харах боломжтой болсон.

Цаашид иргэд энэхүү аппликэйшний тусламжтайгаар төлбөр тооцоо хийх, нийслэл хотын бүх үйлчилгээг авах, иргэд, төрийн захиргааны байгууллагад санал, хүсэлт гаргах, шийдвэрлэлтэд хяналт тавих зэрэг боломж бүрдэнэ. Мөн бид Hotula газрын зургийн систем дээр хаягийн систем, автобусны маршрут, зогсоолын мэдээлэл, бодит цаг хугацаанд автобус хаана явж байгаа байршлыг харах ийм боломжтой болгоно. Бас энэ аппликэйшний шинэлэг зүйл нь иргэдэд хоорондоо chat-лах, мэдээлэл оруулах боломжтой зэрэг нийтийн сүлжээний модуль ашиглана.

Цаашлаад бас нийслэлийн удирдлагууд бас энэ Hotula аппликэйшний чат руу орж vibex-ыг төрийн системд өргөн ашигладаг байсныг тодорхой хэмжээгээр бууруулаад өөрсдийн хөгжүүлж байгаа аюулгүйн системээрээ бас мэдээллийн

урсгалаа солилцуулъя гэдэг бас санаачилгыг бас хотын дарга гаргаад бас бид нар ингээд үе шаттай бас шилжээд явж байгааг бас Hotula гээд аппликэйшн дээр бас нэмж хэлье.

Нийслэлийн нэгдсэн Дата төвийг орчин үеийн модулиар дата төвийн шийдлээр байгуулсан ба олон улсын “Tier 4” стандартын зогсгуур, сервис сүлжээний тоног төхөөрөмж, цахилгаан хангамж, хөргүүрийн систем, галын дохиоллын систем, нэвтрэлтийн систем зэрэг өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжүүдийг суурилуулан нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллаж байгаа. Хүчин чадлыг дурдвал физик сервис нь 117, виртуал сервис 314, сүлжээний тоног төхөөрөмж 48, үндсэн 4 storage бүхэлдээ 2.8 petawatt хэмжээ бүхий сервер storage Улаанбаатарын хэмжээнд ажиллаж байна.

Дата төвд байршиж буй нийслэлийн томоохон core системүүдийг дурдвал нийтийн тээврийн хуучин систем Umoney, нийтийн тээврийн төлбөр тооцооны менежментийн систем, камерын нэгдсэн систем, торгуулийн систем, архивын систем, ERP, авто тээврийн систем, товчоодын төлбөрийн систем зэрэг нийт 200 гаруй систем ажиллаж байна.

2026 онд мэдээллийн технологийн чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа үндсэн бодлогын хувьд Нийслэлийн Засаг дарга бас саяхан Улаанбаатар хотын хэмжээнд программ хангамж хөгжүүлэлтүүдийн бүх байгууллагуудтай уулзаж, программ хангамжуудыг үр ашиггүй программ хангамжуудыг нэгтгэх ажлуудыг идэвхжүүлэх, үргэлжлүүлэх. Дээрээс нь 2026 онд Улаанбаатар хот AI серверийг ашиглаж эхэлж Эрдэнэтийн нөгөө ухаалаг худалдан авалтын систем шиг жишиг дагаж сайн туршлагыг судлан Улаанбаатар хотын хэмжээнд ухаалаг AI систем дата өгөгдлийг ашиглан хэмнэж болох орон тоо болон үйлдлүүдийг судлуулахыг үүрэг болгож 2026 онд бас энэ талын төсөв мөнгөнүүд суугдсаныг бас дуулгахад таатай байна.

2026 онд нийслэлийн төрийн үйлчилгээ болон төрийн байгууллагуудын ажиллагаанд хиймэл оюун ухаан судалгаа хийж, хүний нөөцийн систем, албан хөтлөлт зэрэг систем, худалдан авалтын систем, оператор үйлчилгээний зэрэгт AI хүний оролцоог багасгах талаар саяын хэлснээр ингээд, тэгээд chatpot системийг бас нэвтрүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдаж авахаар төлөвлөөд л байж байна.

Хүний системд бид байгууллагын хүний нөөцийн менежментийг хиймэл оюун ухааны тусламжтайгаар оновчтой бодлого авч хэрэгжүүлэх, албан хэрэг хөтлөлтийн систем дээр иргэдээс ирсэн гомдол, баримт бичгийн хяналт, хуваарилалт зэргээ ангилах хайлт болон дүн шинжилгээг бас автоматжуулсан баримт бичгийг боловсруулсан AI ашиглан хийх боломжтой гэж бас үзэж байгаа.

Өгөгдлийн, гомдлын систем дээр өргөдөл, гомдлыг яаралтай хүлээн авах, ангилах, шийдвэр гаргах хугацааг бас багасгах, харилцан сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх хөгжүүлэлтийг хийнэ. Худалдан авах системийн хувьд бас түрүүн Эрдэнэтийн амжилттай туршлагаас судалж худалдан авалтыг цаашид ер нь хүний оролцоогүйгээр AI систем дээр суурилж хийх боломжийг нэвтрүүлнэ гэсэн 2026 оны зорилт аваад нийслэлийн хэмжээнд ажиллаж байна.

Оператор үйлчилгээний chatbot болон дуут туслахууд цаг хугацаандаа ажлын цагаас үл хамааран 24/7 горимоор нэгэн зэрэг олон мянган хэрэглэгчдэд үнэн, зөв тухайн нөхцөлд тохирсон мэдээллийг хүргэх байдлыг бас 2026 онд AI-тай уялдуулан төлөвлөж байна.

Нийслэлийн хэмжээнд хөдөө орон нутгийн авто тээврийн хэрэгслээс төлбөр, хураамж авах, шалган бүртгэх товчоодыг хот, хөдөө орон нутгийн хилийн заагт шинэчлэн байгуулах, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд:

Гүнт, Тэрэлж, Хоолт, Хөшигт, Түргэн, Морин, Баруунтуруун, Эмээлт зэрэг нийт 8 товчоодыг бүрэн шинэчилнэ. Эдгээр товчоонуудыг шинэчилснээр товчоодоор орж, гарч буй тээврийн хэрэгслийг бүрэн хянаж, албан хаагчдыг ажиллах нөхцөл, боломжийг сайжруулан технологи дээр суурилсан үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ. Өнөөгийн байдлаар бид 26 тэрбум орчим төгрөгийн төлбөрийг товчоодоор нэвтэрсэн тээврийн хэрэгслээр авах ёстой боловч авч чадаагүй байгаа. Тэгээд Улаанбаатар хотод байгаа энэхүү товчоо дээр бас олон гэмт хэргийн зөрчил гаргах, зөвшөөрөлгүй Улаанбаатар хотоос нөгөө коксожсон нүүрс гаргах, дээрээс нь тарваганы мах гэх мэт ингээд олон төрлийн зөрчил гардаг. Үүнийг бас ингэж AI дээр суурилсан байдлаар шийдэж явснаараа оновчлол гарна гэж үзэж байна.

Бид техник, технологийн тусламжтай аль болох иргэдэд чирэгдэл учруулахгүйгээр ухаалаг байдлаар товчоодоо нэвтрэх шийдлийг танилцуулж байгаа.

1 дүгээрт, хотоос гарч буй тээврийн хэрэгслийн улсын дугаарын бүртгэл.

2 дугаарт, төлбөргүй тээврийн хэрэгсэл шууд нэвтрэх буюу улсын дугаар нь хяналтын дэлгэц дээр гарахгүй байгаа зөрчил, төлбөртэй тохиолдолд улсын дугаар болон төлбөрийн мэдээллийг хяналтын самбар дээр гаргах ба авто зогсоол руу орно. Авто зогсоол дээр төлбөр төлөх нөхцөлийг бүрдүүлсэн ч жолооч нь аль нэг төлбөрийн нөхцөлөөр төлбөр төлж зогсоолоос гарах эрхтэй болно. Хот руу орж буй тээврийн хэрэгсэл нь мөн ангилан зорчих хэсгээр хот руу нэвтрэх ба шаардлагатай тохиолдолд хяналтын цагдаа, байцаагч нарт хяналтын бүсээр шалгуулж нэвтрэх эрхтэй болно.

Өнгөрсөн онд хийгдсэн камержуулалтын ажлыг сайжруулж, ирэх 2026 оноос хот нийтийн аж ахуйд хяналтын камерын системийг ашиглах боломжийг бүрдүүлнэ. Энэ нь хог хаягдлын цэгүүдийг камержуулах, нийтийн эзэмшлийн гудамж, талбай дахь хөрөнгийг хамгаалах, нөгөө хашлага, нийтийн эдэлбэрийн тохижилтууд орж байгаа. Тэгээд цаашлаад бид нар бас муур, нохой Улаанбаатар хотод байгаа зэрлэг ан амьтад, аюулгүй байдал, дээрээс нь үер болон цас, нийтийн замын цэвэрлэгээ гэх мэт зүйлүүд дээр бас AI систем болон камержуулалтыг нэвтрүүлж, энэ хот, нийтийн аж ахуй болон иргэдийн хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах чиглэл дээр 2026 онд төвлөрөхөөр ажиллаж байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тогтвортой авто зам, тээвэр” төслийн хүрээнд тээврийн ухаалаг систем буюу ITTS-ийг 2026-2027 онд нэвтрүүлнэ. Тус төслийн хүрээнд хяналтын камер болон мэдрэгч ухаалаг

программ хангамжийн тусламжтайгаар их өгөгдөл дээр анализ хийж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг оновчтой удирдах систем болгох. Улаанбаатар хотын бүх гудамж, замд байрлах гэрлэн дохионы удирдлагын төхөөрөмжийг сольж, гол гудамж замуудын урсгалыг хянах, иргэдэд мэдээлэл өгөх бас боломжийг бүрдүүлэнэ. Замын хөдөлгөөний ачааллыг мэдэрч ухаалгаар өөрөө зохицуулах ийм боломжтой болгохоор бас ингээд Дэлхийн банкны төсөл дээр ажиллаж байгаа.

Сая энэ Дэлхийн банкны энэ “Тогтвортой авто зам” төсөл Улаанбаатар хотын энэ “urban mobility strategy” гадаадын зөвлөхүүдээр Улаанбаатар хотын хөдөлгөөний стратеги, нийтийн тээврийн стратегийг бүрэн гадаадын зөвлөхүүд бас дуусаж танилцуулга хийсэн. Үүний нэг хэсэг болоод уялдуулаад цаашаа энэ замын өгөгдлийн систем ингээд үргэлжлээд ажиллана.

Дэлхийн банкны энэ төслөөс дараах боломжууд бий болохоор байгаа. Замын хөдөлгөөний ачааллыг мэдэрч, ухаалгаар өөрөө зохицуулах, авто замын түгжрэлийг бууруулах, зам, тээврийн ослыг мэдэрч тооцоолох, шуурхай ажиллагааны болон нийтийн тээврийн хэрэгсэлд дэмжлэг үзүүлэх, уулзвараас зохицуулагч цагдааг гаргаж хүний оролцоогүй болгох, замын хөдөлгөөний нөхцөл байдлыг иргэдэд мэдээлэх, хотын зорчилт хөдөлгөөний мэдээллийг цуглуулах, замын хөдөлгөөний бусад системүүдийг нэгтгэх, автоматаар симуляци хийж оновчтой хувилбарыг хадгалах, түүнд суралцах, онлайн горимд бүсчлэл тогтоож өөрийгөө удирдах зэрэг ийм давуу талууд бас үүсэж байгааг бас дурдахад таатай байна.

Танилцуулга хийж дууслаа. Баярлалаа.

Ч.Анар: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг танилцуулсан Түмэндалайн Даваадалай даргад баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Нийслэлийн орлогч дарга Амартүвшин ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хүрэлцэн ирсэн байна.

Тэгэхээр мэдээллийг үргэлжлүүлээд нийслэлийн төсөвт хөрөнгөөр 2020-25 онд хэрэгжсэн мэдээлэл, технологийн төсөл, арга хэмжээний талаар Мэдээлэл технологийн газрын дарга танилцуулахыг хүсье. Мэдээлэл технологийн газрын дарга Түмэнбаяр тавина.

Танилцуулж буй мэдээлэлтэй холбогдолтойгоор гишүүд асуулт асуухаар нэр өгсөн байна. Золжаргал гишүүнээр тасаллаа.

Б.Түмэнбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн мэдээлэл технологийн газарт 20-25 онд хэрэгжүүлсэн мэдээлэл технологийн төсөл, арга хэмжээний жагсаалыг товч танилцуулъя.

20-оос 25 онд мэдээлэл технологийн чиглэлийн системтэй холбоотой нийт 35 ажил нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн байгаа. 5 ажил гадаадын зээл, тусламж буюу төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдсэн ажил байна.

35 жагсаал бүхий ажлаас яг одоогийн байдлаар нийслэлийн хэмжээнд ажиллаж байгаа 24 систем байгаа. Сая 12 сарын 12-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар буюу Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу 11 систем дээр аудит оруулж аудитын дүгнэлтийг үндэслээд цаашид ашиглах, эсвэл актлах гэдэг ийм байдлаар шийдэл гарсан. 24 системийг цааш нь үргэлжлүүлэх гэдэг байдлаар аудитын дүгнэлтийн дагуу хөгжүүлэлтийг хийх, өнгөрсөн жилүүдийн хугацаанд шаардлага хангахгүй системүүд дээрээ ямар ч систем нь шаардлага хангахгүй байгаа юм, юунаас болж ажиллахгүй болсон гэдэг байдлаар танилцуулга, тайлан гаргаж танилцуулгыг үүрэг болгосон байгаа.

Энэний хүрээнд бид бас ажиллаад энэ 25 оны сүүл гэхэд эдгээр 35 системийн дүгнэлт нь албан ёсоор эцэслээд гарч ирэх юм.

Гадаадын зээл, тусламж, төрийн, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдсэн 5 төсөл, хөтөлбөр ерөнхийдөө одоо ч гэсэн үргэлжлээд явж байгаа. 4 ажил нь гэрээ байгуулаагүй, 1 ажил нь байгууллагуудын системтэй холбох ажлуудын туршилтын ажлууд хийгдэж байна гэсэн байдлаар мэдээлэл авсан байгаа. Дууслаа.

Ч.Анар: Мэдээлэл дууссан уу тээ? Мэдээлэл технологийн газрын дарга мэдээлэл танилцуулж дууслаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ ирсэн жагсаалт дээр ингээд харахаар шинэ төслөөр систем хөгжүүлэлт хийлгэсэн төслүүдийн талаар л илүү жагсаалт гарсан юм болов уу гэж мэдээллийг харагдаж байна л даа. Ер нь яг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар маань өөрөө нийт систем худалдан авалт, хөрөнгө оруулалттай холбоотой лицензийн төлбөр эд нар гээд гол нь төлбөрүүд гарах ёстой доо тээ? Тэр талын мэдээлэл байхгүй юм шиг харагдаад байх юм. 1 дүгээр асуулт.

Өөрөөр хэлбэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар чинь янз бүрийн л оффисын системүүд ашиглаж байгаа байлгүй дээ. Бас гаднын янз бүрийн программ ашигладаг байлгүй дээ. Тэгвэл тэрний худалдан авалт, хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл энд яагаад ороогүй вэ гээд нэг асуулт байна.

Хоёрт болохоор энэ ер нь камержуулалт нэлээн их хийж байгаа юм байна. Тэгэхдээ камержуулалт дээр тэр хүний эрхтэй холбоотой, хувь хүний мэдээллийг цааш нь бас задлахгүй байх дээр анхаарсан журам, заавар байдаг байх тийм ээ? Энэ тал дээр мэдээлэл өгмөөр байна.

Дараагийн асуулт болохоор энэ 2013 онд энэ Umoney гээд энэ UB Smart гээд нэг компани байгуулаад л автобусан дээр шинэ төсөл эхлүүлсэн. 13 сая ам.доллар-ыг Солонгосын компаниудтай хамтарч хийсэн санагдаад байна. Ингээд харсан сая бол UBcard апп гээд шинээр Монгол Улс өөрсдөө 6, 7 сая доллароор бас тийм төсөл хэрэгжүүлж байгаа юм байна гэж харагдаж байна. Тэгэхээр нөгөө өмнөх хэрэгжүүлсэн 13 сая долларын төслийн үр дүн юу болсон бэ? Тэнд байсан хөрөнгүүд чинь яасан бэ? Яагаад ингээд шинээр, цоо шинээр программ бичиг болоод явчлав? 22 тэрбум төгрөгийн төсөвтэй ийм программ хангамжийн асуудал яригдчихсан явж байна. Энэ дээр мэдээлэл авъя.

Дараагаар нь энэ нэгдсэн платформ гээд Hotula гээд аппликэйшний тухай бас яригдаад байна. Энэ хэний өмч вэ? Нийслэл болохоороо маш их өндөр хэмжээний дүнтэй захиалга өгөөд олон программ хийлгээд байна. Тэгээд тэр нь

нийслэлийн өмч юм уу эсвэл тэр хийгээд байгаа программ хангамжийн компанийн өмч юм уу? Бид нарын Их Хурлаас ер нь Монгол Улсын барьж байгаа бодлого болохоор ер нь программ хангамжийн үйлдвэрлэл хийж байгаа компаниудаа дэмжье гэж бид нар яг бодлого бариад байгаа. Тэгэхээр энэ программ хангамжууд маань тухайн нийлүүлэгч компаниудын өмч байна уу эсвэл нийслэлийн өмч байна уу гээд нэг ийм асуулт байгаа. Энэ асуултад хариулт авъя.

Ч.Анар: Хэн хариулах вэ? Нийслэлийн Засаг даргын 2 дугаар орлогч Л.Амартүвшин. Микрофоныг өгье.

А.Амартүвшин: Нийслэлийн Засаг даргын орлогч Амартүвшин байна. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Хүний эрхийн асуудлаар гэх юм бол бид нар олон нийтийн газар, талбай, олон нийтийн олноор цуглардаг эдгээр талбайн камерын холболтыг нэгтгээд эхэлсэн байгаа. 2025 онд та бүхэн бас тайлангаас харсан байх замын хөдөлгөөний камерын нэгдсэн системийг нэвтрүүлээд, тэрний тест яваад AI-аар замын хөдөлгөөний 10 төрлийн зөрчлийг бүртгээд эхэлсэн байгаа. 1 сарын 1-нээс энэ маань торгуулийн хэлбэр рүү шилжиж ороод эхэлнэ. Яг энэнтэйгээ адилхан бид нар сургууль, цэцэрлэг, албан байгууллагуудын гаднах камержуулалт, олон нийтийн цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн газар, талбай, явган хүний зам, эдгээр камержуулалтыг бас энэ нэгдсэн систем рүү холбоод AI-аар хяналтыг тавихаар явж байгаа.

Хүний эрхийн хувьд гэх юм бид нар нөгөө оффисын дотор камер ямарваа нэг баар, цэнгээний газрын дотоод камер, эдгээр дотоод камеруудыг холболтыг манай нийслэл авахгүй байгаа. Энэ бол тухайн байгууллагын өөрийнх нь дотоод болон хувь хүний нууцтай холбоотой учраас бидэнд зөвхөн нийтийн талбай, талбар руу харсан эдгээр камертай холболтыг бид нар хийж байгаа.

Umoney нь та бүхэн мэдэж байгаа байх БНСУ-ын Tmoney-тэй буюу метро, такси гээд ерөнхийдөө энэ юутай хэрэглэж явдаг эдгээр Tmoney-г зохион бүтээсэн компанитай хамтарч Umoney-г хийсэн юм байна лээ. Ингэснээр Улаанбаатар хот Umoney- гоос энэ юугаа бүрэн худалдаж аваад, эрхээ гэсэн үг шүү дээ. Эрх, систем бүх юмаа Tmoney-гоос энийгээ худалдаж аваад одоо бол UBCard гээд 100 хувь нийслэлийн өмч 100 хувь нийслэлийн мэдэлд байгаа ийм компани байгаа. Тэрнээс автобуснаас, зорчилт тээврээс олж байгаа бүх орлого энэнтэй холбоотой бүгд ингээд нийслэл рүү 100 хувь орж байгаа. Ямарваа нэгэн хувьцаа ч юм уу хувааж байгаа, орлогоо хувааж байгаа тийм юм байхгүй. 100 хувь Монголд орж байгаа. 22 тэрбум нь энэ худалдаж авах, эрхийг худалдаж авах энэ зардал руу орсон мөнгө байгаа.

Hotula аппликэйшн нь хувийн компани дээр зохион бүтээгдээд нийслэлтэй хамтран зохион байгуулж байгаа. Hotula аппликэйшний нийслэлтэй холбоотой бүх үйлчилгээ нь эрхийн хувьд нийслэл дээр эрх нь хадгалагдана. Үйлчилгээ нь болон техникийн үйлчилгээ, техникийн холбогдолтой цахим холбогдолтой асуудлыг Hotula хэрэглээд явж байгаа. Анхны хэрэглээ нь та бүхэн мэдэж байгаа байх Тавантолгой түлшний хэрэглээг оруулж ирж нэвтрүүлж, одоогоор нийт 172 мянган айл өрх түлш худалдаж авч байгаагаас нийтдээ 65 мянган айл өрхүүд нь болоод Hotula аппликэйшнийг ашиглаад ингээд орж ирж байгаа.

Hotula аппликэйшнийг Дан болон ХАӨМС-тай бид нар холболтыг хийгээд дууссан байгаа. Ингэснээр буюу Hotula аппликэйшнээр холбогдоод айл өрхүүд маань түлшээ авах, тэрийгээ хянах, байршлууд, түлш борлуулж байгаа

байршлуудынхаа цэгүүдийг хүртэл ингээд авч үзэж харж боломжууд нь ингээд нээгдчихсэн явсан.

Цаашид энэ Hotula аппликэйшн яах юм бол бүүр мөн танилцуулгаар та бүхэн харсан байх. Энэ өөрөө фэйсбүүктэй ижил, өөрөө олон нийтийн сүлжээ маягаар ажиллаж явна. Энэ дээр нь нийслэл төвтэй байна. Энэ дээрээс нь нэмээд хэлэхэд энэ 12 сарын сүүлээр 1 сарын эхээр бид нар ногоон онооны системийг оруулж ирж танилцуулна. Ингэснээр сайн Улаанбаатарын хотын иргэн ингээд ногоон оноо цуглуулж хотын үйлчилгээ дээр аваад дээрээс нь цуг.../минут дуусав./

Ч.Анар: Нэмж 1 минут өгье.

А.Амартүвшин: Тэгээд нэмж цуглуулсан ногоон оноогоороо нийтийн тээвэр дээр хөнгөлөлт үзүүлэх, энэ нөгөө нэг татвар, тогны мөнгө, нүүрс дээрээ хөнгөлөлт эдлэх эдгээр юмнууд дээр ногоон оноог хэрэглэх боломжтойгоор нээгдүүлж өгч байгаа.

Ногоон оноог ямар хэлбэрээр тухайн иргэн маань цуглуулах юм бол нөгөө нийтийн тээврийг ашигласан, тодорхой хэмжээний өдөрт алхах ёстой километрээ алхсан, мөн скүүтер, жет гээд эд нарыг ашигласан эдгээр иймэрхүү байдлаар ногоон оноог, тэгээд хогоо ангилан ялгасан ч гэдэг юм уу тухайн улиралдаа, тухайн сардаа, тухайн жилдээ замын хөдөлгөөний дүрэм зөрчөөгүй гэдгээрээ ч юм уу ингээд ногоон оноо цуглуулснаар ийм төрийн үйлчилгээ болон тог цахилгааны мөнгөн дээрээ хүртэл хэмнэлт үүсгэж, discount буюу хөнгөлөлт эдлэх ийм платформыг оруулж нэвтрүүлж байгаа.

Ч.Анар: Соронзон гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Эхний хэд асуусан системийн худалдан авалт, лицензийн төлбөртэй холбоотой мэдээллүүд ерөөсөө байхгүй байна. Энийг.

Ч.Анар: Мэдээлэл технологийн газрын Дэд бүтэц, техник хэлтсийн дарга Баттулгын Түмэнбаяр.

Б.Түмэнбаяр: Асуултад хариулъя. Түмэнбаяр лицензтэй холбоотой зардал маань урсгал зардал дээр суугддаг. Манай Нийслэлийн Засаг даргын Тамгын газар ойролцоогоор 225 албан хаагчтай. 225 албан хаагчийн оффис болон антивирусийн программ хангамжийн зардал мэдээлэл технологийн урсгал зардал дээр суусан учраас энэ танилцуулга дээр ороогүй байгаа. Энэ танилцуулга дээр дандаа хөрөнгө оруулалтын томоохон ажлуудтай холбоотой танилцуулгуудаа оруулсан байгаа. Жил болгон ойролцоогоор 110 сая орчим төгрөг бид урсгал зардалдаа 225 албан хаагчийн яг энэ аюулгүй байдлын чиглэлийн лицензүүд дээр зарцуулагдаж байгаа.

Ч.Анар: Соронзонболд гишүүн дахиж тодруулъя.

Л.Соронзонболд: Нөгөө энэ олон хэрэгжиж байгаа төслүүд сүүлд нь нийслэлийн өмч болоод байгаа юм уу тухайн хувийн боловсруулсан компанийн өмч болоод бүртгэгдээд яваад байгаа. Одоо энэ чинь нэлээн том том дүнтэй программ хангамжийн үйлчилгээ, худалдан авалтууд хийгдсэн байна шүү дээ өнгөрсөн хугацаанд. Тэр чинь зарим нь ойлголоо. Тэгээд тухайн компани бас Hotula-г жишээлбэл боловсруулсан компани хийсэн юм байна.

Жишээлбэл, Umoney гээд л аппликэйшн нь UBcard гээд болсон юм байна тээ? Тэгтэл UBcard гээд аппликэйшн чинь та хэд худалдаж авч байгаа биз дээ? Тэгээд “Ай Си Ти” гээд групп компаниар танайх бас 20 гаруй тэрбум, 22 тэрбум төгрөгөөр бас хөгжүүлэлт хийлгэсэн байна шүү дээ. Тэр чинь жишээлбэл “Ай Си Ти” групп компанийн өмч юм уу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын өмч юм уу? Хэрвээ “Ай Си Ти” групп компанийн өмч юм бол бас тэнд чинь лицензийн төлбөр төгрөгөөр гарах ёстой биз дээ ер нь бол гэх мэтчилний л асуулт асуугаад байгаа байхгүй юу.

Ч.Анар: Баттулгын Төмөр дарга тодорхой хариулъя.

Б.Түмэнбаяр: Захиалагч байгууллага нь Нийслэл Засаг даргын Тамгын газар байгаа. Гүйцэтгэгч байгууллага нь аль компаниас үл хамаараад тухайн системийн эх код болон патентын эзэмшигч нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын өмч гэж явагдаж байгаа гэрээн дээрээ .

Цаашдын ашиглалт, үйлчилгээ дээр бид нар яг энэ өөрсдийн хөгжүүлсэн зардал дээрээ лицензийн зардал биш ашиглалт, үйлчилгээг буюу maintenance-ийн зардлыг ерөнхийдөө суулгаад явдаг. Эхний 2-3 жилд тухайн компани maintenance-т гэрээний дагуу үнэгүй үзүүлнэ. 4 дэх жилээсээ тодорхой хэмжээний ямар хэмжээний үйлчилгээ авахаасаа хамаараад урсгал зардал дээрээ суулгаад явахаар ингэж төсөвлөгдсөн байгаа.

Ч.Анар: Тэгэхээр нөгөө оюуны өмч болоод их код өмчлөгч нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар гэж ойлгож байгаа тээ? Ринчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Нийслэлийн төсвийн хөрөнгөөр гээд асуух хэд хэдэн юм байна. Болж байгаа юмнууд байгаа байх би дандаа болохгүй юм ярихаар дандаа эсэргүүцээд байгаа юм шиг юм ойлгогдоод байх шиг байна.

Энэ 1 дүгээрт энэ сервер байна шүү дээ. Энэ яг хаана байрлаж байна? Орбитдоо юу? Зүгээр хэлчихгүй юу? Энэ серверийнхээ аюулгүй байдлыг яаж хангаж байгаа юм бэ гэдэг нэг асуудал.

Зөрчил илрүүлэх камер гээд энд тэндгүй ингээд жижиг сажиг 200 сая гэж ингэж тавьж явж байснаа авто замын уулзвар гээд нэг том дүнтэй юм яваад байгаа юм. Тэгэхээр энэ авто замын уулзвар чинь өөрөө хэчнээн авто замын уулзвар камержуулаад байгаа юм? Ер нь үнэлгээг нь яаж хийдэг юм гэдэг нэг асуудал.

3 дугаарт нь тэр программ хангамжийг энэ Соронзон гишүүн асуугаад байна. Би бас асуух гээд байгаа юм. Яг эзэмшигч нь хэн байх юм. Жишээлэх юм бол энэ 5 дээр нэг байна шүү дээ. Энэ программ хангамж гээд л байж байна. Орон нутгийн өмчийн бүртгэл гээд л. Энэ 1 тэрбум 430 сая гээд тавьчихсан. Энэ чинь ирэх жил дахиад л гарах уу гарахгүй юу, хөгжүүлэлт нь яаж явах юм, лицензийн хугацаагаа сунгах гээд дахиад тэрбумаараа гараад яваад байх программууд байна уу? Эсвэл өөрсдөө дотроо бас хөгжүүлээд явах боломжтой тийм программууд байна уу?

Энэ зам ашиглалтын төлбөртэй холбоотой энэ судалгаа, зөвлөх үйлчилгээний гээд аймаар зардлууд гарчихсан байх юм. Эхлээд овоо гайгүй 80, 90

сая явж байснаа сүүлдээ 970 сая төгрөг ч байж байх шиг. Энэ зөвлөх үйлчилгээ ингээд тэрбумаар нь аваад байх хэрэг байгаа юм уу? Тэгээд тэрнийхээ дараа нь та нар өөрсдөө энэ дээр сайн хараарай авто зам ашигласны төлбөр авах цэгүүдийн программ хангамж, техник тоног төхөөрөмж гэхээр 370 сая төгрөг байж байдаг. Яагаад ингээд зөвлөх үйлчилгээ нь 970 сая байгаад байдаг юм. Яг хэрэгжиж байгаа юм нь болохоор 370 сая төгрөг байгаад байна. Энэ чинь өөрөө хэрэглэж байгаа тоног төхөөрөмжөөсөө илүү үнэтэй ийм зөвлөх үйлчилгээ аваад яваад байдаг юм уу? Энэ бас он дараалсан 2, 3-н юм харагдаад байна л даа.

4 дүгээрт нь энэ Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс байгаа тээ? Энэ нөгөө камерын систем чинь энэ буруу мэдээлэл нааш нь цааш нь явуулаад байх юм. Энийгээ яаж засах юм? Энэ алдаатай мэдээллүүдийг ер нь яах юм? Одоо над дээр гэхэд миний бүртгэл дээр байдаггүй 3, 4 тээврийн хэрэгслийн таныг торгочихлоо шүү, энийгээ төлөхгүй бол алдагдалд алданги тооцно шүү гэсэн ийм мессежнүүд ирээд байх юм. Буцаагаад явуулъя гэхээр хаашаа явуулах нь мэдэгдэхгүй зүгээр л мессеж ирчхээд байдаг. Дээрээс нь энэ хөдөлгөөнд оролцоогүй байхад торгочихсон байх юм гэдэг асуудлууд ир.../минут дуусав./

Ч.Анар: Хэн хариулах вэ? Эхний асуултуудыг Мэдээлэл технологийн газрын дарга, хэлтсийн дарга Түмэнбаяр.

Б.Түмэнбаяр: Асуултад Түмэнбаяр хариулъя. Эхний асуулт нь Нийслэлийн дата төв маань Нийслэлийн нутгийн захиргааны 5 дугаар байр буюу СБД-ийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт хуучнаар бид нар Инновац хабын төв дээр байршиж байгаа. Түрүүн танилцуулга дээр гарсан бид хэд олон улсын стандартын Tier 4 түвшний ерөнхийдөө дата төвийг, модулиар дата төвийг байгуулсан. Энэхүү дата төв дээр нийслэлийн нутгийн захиргааны бүх байгууллагуудын 200 гаруй системүүдийг бид нар хэвийн үйл ажиллагааг нь хангаад ажиллаж байна.

Аюулгүй байдлын хувьд мэдээж 2 түвшний аюулгүй байдлыг хангаж байгаа. Түрүүний хэлдэг хэрэглэгчийн түвшний аюулгүй байдлыг бид нар лиценз, endpoint лиценз болон компьютер дээрх үйл ажиллагааг нь хянаж байгаа.

Тоног төхөөрөмж дээр бид нар firewall SIM энэ тэр суулгаад аюулгүй байдлыг бид нар өөрсдийн хэмжээнд өндөр хангаж байгаа гэж үзэж байгаа.

Мөн Мэдээллийн кибер аюулгүй байдлын газраас бид нар жилд нэг удаа зөвлөмж авдаг. Хяналт шалгалт хийгддэг. Тэр зөвлөмжийн дагуу бид нар бас биелэлтийг хангаж ажилладаг.

Дараагийн асуултыг лицензийн төлбөр одоо яг нийслэлийн хэмжээн дээр байгуулж байгаа системүүдийн хувьд лицензийн төлбөр жил болгон гаргадаггүй. Өмнө хэлсэнчлэн 2-3 жилийн хугацаанд тухайн байгууллага нь хариуцаж байгаад 3 дахь жилдээ бид нар өөрсдөө хүлээж авч цаашдаа үйл ажиллагаагаа ашиглалтыг нь хариуцдаг. Тэр хугацаанд бид нар тухайн системийг хариуцаж авах албан хаагчдыг бэлтгэдэг. Шаардлагатай гэж үзвэл бид нар түрүүний хэлдэг жилийнх нь сервисийнх нь үйлчилгээний гэрээ хийгээд авч явдаг. Энэ дээр бас ганц, хоёр юу гэдэг юм сайн жишгүүд бас байна. Бас сайн хийж байгаа компани байна. Муу хийж байгаа компани байна. Maintenance-ээ үзүүлж чадахгүй муу хийж байгаа компанийг тухайн гэрээг нь тухайн жилд нь цуцлаад тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулалтаа хийгээд явдаг ийм процессоор явж байгаа.

Системүүдийн хийгдсэн системүүдийн хувьд ялгаатай тэр 5 дугаар жагсаалт дээр өмчийн систем байна гэж байсан. Тэр өмчийн систем бол нийслэлийн хэмжээнд ерөнхийдөө бас тодорхой хэмжээний тоног төхөөрөмжүүд олширч байна, эд хогшлууд олширч байна гэдэг байдлаараа нэг нэгэнгүй бүртгэлийн ийм нэгдсэн систем хийгдэж байгаа. Энэхүү системээр цаашдаа бид нар ерөнхийдөө бас ашиглаад аудит ч тэр, нийслэлийн хэмжээнд жишээлбэл нөгөө яг бүртгэл хийж байгаа хүмүүст маань ажлыг нь хөнгөвчлөх гэдэг үүднээс хийгдээд явж байгаа систем байна юм.

Нөгөө талаараа бид нар бас нэг бас нэг юм хэлэхэд одоо нийслэл дээр гарч байгаа системүүд маань эргүүлээд улсын систем болдог. Жишээ нь Шилэн данс байна. ERP байна гээд. Ингээд нийслэл дээр хэрэгжиж байгаа бас сайн системүүдээ эргүүлээд улсад хэрэгжүүлж байгаа ийм жишиг байдлаар хэрэгжээд улс аваад явдаг ийм систем байдаг. Тэрэнтэй адилхан бас энэ өмчийн системүүдийг бас бид нар тэр байдлаараа нийслэлийн хэмжээний бүх тоног төхөөрөмж, эд хогшлуудыг нэг нэгэнгүй бүртгэх ямар ч эд хөрөнгө шамшигдахгүй байх гэдэг байдлаар ерөнхийдөө системийг хөгжүүлсэн ийм систем байна юм.

Ч.Анар: Замын хөдөлгөөний удирдлагын төвийн дарга Хувьзаяа.

Ч.Хувьзаяа: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Асуултад хариулъя. Өмнөх гишүүний асуусан асуултад гүйцээгээд нэмэлт тодруулгаа хариулчихъя гэж бодлоо. Хүний эрхтэй холбоотой ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ гэдэг ажлын хүрээнд 2025 онд Нийслэлийн Засаг даргын А1487 гэсэн захирамжаар Теле камерын нэгдсэн төв болон дэд төвүүдийн системийг хэн ашиглах вэ, яаж ашиглах вэ, юунд ашиглах вэ гэдэг журмыг баталсан. Тус журмаар системийн эзэмшигч мэдээлэл хариуцагч нь нэгдсэн төвийн мэдээллийн эзэн байна. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер хамгаалах тухай хуулийг эшлээд Кибер аюулгүй байдлыг хамгаалах тухай нийтлэг журмыг баримтлан ажиллаж байгаа.

Мэдээллийн хувьд эрүүгийн хэрэг үүссэн тохиолдолд тусгай чиг үүргийн байгууллагад шаардлагатай мэдээллийг албан бичиг үндэслээд өгч байгаа. Гэхдээ өгөхдөө нэг хувийг архивт хадгалаад ийм бичлэгийг ийм зорилгоор ийм гэмт хэрэгт зориулаад өгсөн шүү гэдэг архивыг үйлдээд явж байгаа.

2 дахь хэрэглэж байгаа нь хойшлуулшгүй ажиллагааны үед. Энэ тус журамд зааснаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааны үед мөрдөгчийн саналыг үндэслээд яг тухай бүрд нь ашиглуулж байгаа ийм л процесс явж байгаа. Өөр ямар ч зорилгоор ашиглуулахгүй байгаа гэсэн үг.

Зөрчил илрүүлэх камер 2023 оноос өмнө бол 88 байршлын 160 камер ажилладаг байсан юм. Энд нь 1 дүгээр эгнээ, хурд хэмжих камер, улаан гэрэл, цагаан шугамын зөрчил авч байсан. 160-хан камертай 23 оноос хойш өмнө ажиллаж байсан. 23 онд уулзвар дээр нөгөө саяын нэвтрүүлсэн байгаа 10 зөрчлийг илрүүлэх боломжтой ухаалаг камерын системийг 5 уулзвар дээр нэвтрүүлсэн. 25 онд 150 байршилд нэмэгдүүлж бүх уулзварыг зөрчил, торгууль, шийтгэл оногдуулахаасаа гадна замын хөдөлгөөний зорчилт хөдөлгөөний судалгааг хийх, үндсэн датаг бүртгүүлэх зорилгоор энэ камерын системийг нэвтрүүлсэн байгаа.

Алдаатай зөрчлийн хувьд мэдээж эхнээсээ алдаа гараад явж байсан. Маш их алдаа гарсан. Мессеж илгээсэн. Алдаатай зөрчлийн хувьд бид нар тухай бүр дээр нь систем дээр засвар хийж энэ программ дээр суулгаж байгаа дүрмүүдээ засвар хийгдэж байна. Бас нөгөө байгалийн үзэгдлээс болоод салхи замын тэмдэг, тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухайн уулзварын зөрчил илрүүлэх системүүдийг унтраагаад алдаатай зөрчлийг маш их багасгасан байгаа. Өдөрт сая зөрчил бүртгэгдлээ гэж бодоход алдаатай зөрчил 20-30 мянга гэдэг чинь 3 хувьтай л алдаатай зөрчил гарч байгаа. Мессеж андуурч очиж байгаа тохиолдол Автотээврийн Үндэсний төвийн бүртгэлийн санд бүртгэлтэй эзэмшигч, өмчлөгчийн утасны дугаараа илгээж байгаа учраас Автотээврийн Үндэсний төвийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг сайжруулаач гээд Автотээврийн Үндэсний төвд хандаад мэдээллийг сайжруулахаар ажиллаж байгаа.

Хөдөлгөөнд оролцоогүй байх үед торгууль ирлээ гэдэг мэдээлэл иргэдээс ирж байгаа. Энэ улсын дугаарын стандарт шаардлага хангахгүй “А”, “Д” үсэг ялгагддаггүй, “А”, “Л” үсэг ялгагддаггүй. Яг энэ нөгөө улсын дугаарын стандартаа барьж хэвлээгүй, эс үгүй бол тодорч, бүдгэрч яаснаас болж буруу таних асуудлууд гарч байгаа. Гэхдээ дугаар таних систем дээр хиймэл оюуны модель ажиллаж байгаа. Үйлдвэрлэгчийн таних дээр модель ажиллаж байгаа, өнгө таних дээр ажиллаж байгаа. Энэ нь бага багаар сайжраад явж байгаа. Дугаар таних дээр 97 хувийн баталгаатай ажиллаж байгаа. Бага сага алдаа бол гарч байгаа. Баярлалаа.

Ч.Анар: Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Саяын ингэх юм байна. Одоо камерын хяналт сайжирчихсан. Одоо наадах чинь тэгвэл 155 уулзвар дээр ч юм уу ингээд хийгдээд явж байгаа гэсэн үг байна шүү дээ тийм үү? Бараг орчхож байгаа л гэсэн үг юм байна. Тэгэхээр дараа нь хөдөлгөөний нягтрал байдаг юм уу тэр урсгалыг ингээд судлах зорилгоор дахиад ингэж мөнгө төгрөг зарахгүйгээр наадах чинь өөрөө ухаалгаар датагаа боловсруулаад явж байна гэсэн үг гэж ойлголоо. Мөн үү?

Ч.Анар: Индрийн микрофоныг өгье.

Ч.Хувьзаяа: Дата мэдээлэл цуглуулах зорилгоор мөнгө зарахгүй. Одоо тухайн камераас авсан мэдээлэлд үндэслээд гэрэл дохиогоо зөв удирдахын тулд бид нар гэрэл дохионы удирдлагын системийг шинэчилж Дэлхийн банкны санхүүжилтийг ирэх онд хэрэгжүүлэх гээд ажиллаж байгаа.

Ч.Анар: Батболд гишүүн дахиж тодруулъя.

Р.Батболд: Нийслэлийн орлогчоос 2 юм асуучихъя. Сая би зам ашиглалтын төлбөртэй холбоотой тэр зөвлөх үйлчилгээ энэ тэр гээд 23 онд гарчихсан юмнууд байна шүү дээ. Би тэрийг асуугаад байгаа юм. Тэгэхээр дахиад тийм юм хиймээргүй байна. Зүгээр хөдөөгөөс орж ирж байгаа машин дээр замынхаа хураамжийг авах төхөөрөмжөө л аваачаад тавьчихгүй аваачаад тэрийг судлаад л нэг их сүйд болоод тэрбум төгрөгөөр тийм ажил хийгээд байх ер нь шаардлага байдаг юм уу?

2 дугаарт гэх юм бол энэ үнэлгээгээ яаж тооцоод байгаа юм бэ гэдэг асуудал байгаа юм. Тэр 12, 13 хоёрыг хараарай. Нийслэлийн ЕБС-ийн гадна орчны эрсдэлтэй хэсгүүд гээд 5-н сургууль дээр 500 сая төгрөгөөр камержуулалт хийсэн юм шиг байна бодвол. Тэгсэн мөртөө БГД-ийн сургууль, цэцэрлэгийн

камержуулалт, дагалдах тоног төхөөрөмж нь гээд 400 сая төгрөг байж байдаг. Бүхэл бүтэн дүүргийн хэмжээний сургууль, цэцэрлэгийн камержуулалтад 400 сая төгрөг тавьчихаад 5-н сургуулийнх дээр 500 сая төгрөг тавьчихсан байгаад байгаа.

Ч.Анар: Энэ Батболд гишүүнд 1 минут өгье.

Р.Батболд: Тэгээд энэ 2 асуудал.

3 дахь нь болохоор тэр өмчийн бүртгэлтэй холбоотой программ хангамж гээд байна шүү дээ. Энэ хэдэн оноос хойших нийслэлийн өмч ер нь хамрагдаж орох гээд байгаа юм бэ гэдэг асуудал. Өнөөдрийнхөө байгааг л бүртгээд урд талынх нь хамаагүй гэж хаях гэж байна уу, эс үгүй бол бүүр 90 оноос хойшхыг нь хөөж энэ рүү оруулаад бүртгэлийг нь хийгээд явах юм уу? Одоо Нийслэлийн Засаг дарга тэр Хатанбаатарын эмнэлэг гээд л ингээд нийслэлийн өмчид байсан газруудаа бид нар буцааж аваад байна гэж байна шүү дээ. Яг энэ шиг ингээд дундуур нь ингээд зувчуулчихсан гэдэг юм уу хувьдаа олгочихсон юм уу ийм газрууд зөндөө байгаа шүү дээ ер нь бол. Тэгэхээр энэний бүртгэл орох юм уу, эсвэл өнөөдрийнхөө түвшинд л байгаа хөрөнгөө бүртгэхээд энэнээс хойш нь бүртгэж явах гэж байна уу?

Ч.Анар: Засаг даргын орлогч Амартүвшин индэр дээрээс.

А.Амартүвшин: Батболд гишүүний асуултад хариулъя. Зөвлөх үйлчилгээний талаар танайд мэдээлэл байна уу. Зөвлөх үйлчилгээний талаар би тан дээр мэдээллийг холбогдох байгууллагаас нь аваад бичгээр танд хүргүүлж өгье. Яг надаа энэ зөвлөх үйлчилгээний талаар яг дэлгэрэнгүй мэдээлэл надаа яг одоогоор байхгүй байна.

Сургуулиудын асуудал гэх юм бол ийм байгаа. Эхний хөрөнгө гарч байгаа сургууль нь болохоор үндсэн дүүрэг болгон дээр дэд төвүүд байгаа. Дэд төвүүд дээр холбох, дэд төвүүдийн холболтын ажил серверүүдийн эдгээр холболтын ажил дээр хөрөнгө мөнгө гарсан.

Дараачийн сургуулиуд нь 5-н сургууль ойролцоо 400-450 гарахаар чинь 1 тэрбум төгрөг нь гарахаар нөгөө сая төгрөг гарахаар нөгөө үндсэн сервертэйгээ холбогдчихсон зөвхөн нөгөө өргөтгөлийн ажил, шугам сүлжээний таталтын ажил, түр болон баг серверийн буюу минимал дата серверийн эдгээр дээр хөрөнгө мөнгө нь гарч байгаа. Яг үндсэн нөгөө том сервер буюу бүх датагаа цуглуулж байгаа дэд төвүүдтэй холбож байгаа болон үндсэн төвтэйгөө холбож байгаа сургуулиуд дээр зардал өндөр гарч байгаа. Яг би танд хэлж байсан бүх Улаанбаатар хотод явж байгаа хувийн болон улсын бүх сургууль, цэцэрлэгийг манай нэгдсэн хяналтын төвтэй холбож байгаа. Тэгэхээр яг СХД-т гэхэд яг тийм үндсэн дата боловсруулдаг нөгөө AI-ийнх нь өөрийнх нь боловсруулж чадах тийм дата сервер нь байх ёстой болчихоод байгаа юм байна лээ.

Тийм болохоор тэр сервер нь өөрөө тэнд датагаа өөрөө процесс хийгээд, шүүгээд, ялгаад тэгээд үндсэн сервер рүүгээ зөвхөн шүүлтүүрээ гаргаж явдаг. Бусдууд нь тэр үндсэн сервер рүүгээ мэдээллээ өгөөд яг манай юу байгаа шүү дээ дата бааз байгаа эднийх рүү, эднийх рүү зөвхөн шүүгдсэн тоон материал нь орж ирдэг ийм байдлаар ингээд явж байгаа. Тэгэх юм бол заавал нэгдсэн төвийнхөө ачаалал.../минут дуусав./

Ч.Анар: Индрийн микрофонд 1 минут.

А.Амартүвшин: Нэгдсэн төвийн ачааллыг 50-55 хувиар бууруулж байгаа. Тэгэхээр гацах, гацалдах, дээрээс нь удаан унших, мөн заримдаа data transfer хийж байх хоорондоо алга болох, устгах энэ асуудал ингээд 100 хувь шийдэгдэж байгаа гэдэг асуудал орж ирж байгаа. Оноо хэдэн оноос хойш бүртгэж байгаа юм.

Б.Түмэнбаяр: Түмэнбаяр үргэлжлүүлж хариулъя. Нэмээд тодруулж хэлэхэд төсөл, хөтөлбөр дээр тухайн байгууллагууд бас нэршлээ өгөхдөө ингээд зарим нэг нь ингээд сургууль, цэцэрлэг, дагалдах тоног төхөөрөмж гээд том том нэршлээрээ орчихдог. Яг тухайн техникийн даалгаврыг нь үзвэл объём нь бас жижиг хэмжээний объёмтой. Тэгээд нэршлээ өгөхдөө зарим газрууд түрүүний хэлдэг янз янзын нэршлээр өгч байгаа учраас техникийн даалгавар дээрээ л тухайн тоо хэмжээ нь бас ялгардаг юм гээд.

Хоёрт нь өмчийн систем дээр нийлүүлж байгаа систем нь одоо яг энэ манай ялангуяа энэ Нийслэлийн энэ нягтлан, нярвуудын хөтөлж байгаа системүүд өөрсдөө нэг системтэй. Тэгээд тэрэнд бүртгэж авахдаа анхнаасаа гэрээний дугаараар ч юм уу ингээд ийм бүртгэлээсээ авхуулаад ерөөсөө дандаа буруу бүртгэдэг. Үндсэн хөрөнгө юм уу, бараа материалын жагсаалт юм уу, актлах хөрөнгөө ялгаж чаддаггүй, зураг хөрөг байдаггүй. 2 жилийн дараа ч юм уу 2 сарын дараа ажлаас гараад явчихлаа гэхээр тухайн гарсан албан хаагчийн хөрөнгө дээр нь ямар хөрөнгө байсан тэгээд мэдэгддэггүй. Нягтлан, нярав нь гараад явчихвал өмнө нь энэ үзүүлэлт нь ч өөрчлөгдсөн юм уу гэдэг байдлаар ямар ч тийм нотолгоо, баримтгүй байсан учраас энэхүү системийг зайлшгүй ч нэвтрүүлэх шаардлагатай байсан юм.

Тэгэхээр энэ систем нь одоо анх нийслэл л дээр Нийслэлийн өмчийн харилцааны газар дээр байгаа бүх хөрөнгийг нэгдсэн байдлаар систем рүү тэр чигт нь оруулж байгаа гэсэн үг. Шинээр 25 онд хийж байгаа төсөл, хөтөлбөрүүд давхар орно. Тэрнээс өмнөх бид нарын байгаагаар 2009 оноос хойших хөрөнгүүд бүгд давхар орж байгаа. Тэгээд нэлээн ч олон албан хаагч нар сая солигдсон, нэлээн ч олон бас юу гэдэг юм систем нь өөрчлөгдсөн. Энэнээс цааш ерөнхийдөө бас ингэж явж болохгүй юм бай.../минут дуусав./

Ч.Анар: 1 минут нэмж өгье. Тодорхой тэгээд тэр камержуулалтын талаар бас хариулах нь байна.

Б.Түмэнбаяр: Тэгээд тэр утгаараа энэ өмчийн системийг гаргасан. Улс дээр бас өмчийн систем тодорхой хэмжээний явж байгаа гэсэн. Манай энэ систем улсын систем аль ч системтэй интеграци хийх бүрэн боломжтой гэдэг байдлаар хөгжүүлэгдээд явж байгаа. Тийм 9 оноос хойш. Тэрнээс урдах нь бас мэдээллийн санд байгаа үед бүгд орж явж байгаа. Бид нар Өмчийн харилцааны газартай системтэй нь интеграци хийгээд одоогийн байдлаар 9 оноос хойшхыг нь бид нар эхний байдлаар оруулаад аваад явж байгаа. Албан ёсоор бүрэн яг 100 хувь хүлээлцэж явагдаагүй байгаа.

Ч.Анар: Батболд гишүүний асууж байгаа асуултад албан бичгээр хариулт өгөхийг хүсье. Ж.Золжаргал гишүүн асуулт асууна уу.

Ж.Золжаргал: Ер нь нийслэлийн цахимжилтын асуудал нэг талдаа бас хурдацтай явагдаад ялангуяа энэ камерын хяналт, AI энэ тэр гээд явж байгаа.

Сүүлийн 2 жил миний мэдэхийн 2 удаагийн төсөв дээр аюулгүй байдалтай холбоотой иргэдийн ялангуяа хууль сахиулах байгууллага, цагдаагийн их дэмжлэгтэй байгаа шүү дээ. Улсын төсөв дээр ч тэр, орон нутгийн төсөв дээр ч тэр нэг талаас.

Нөгөө талаасаа тийм учраас төсвийн хэмжээ бас их нэмэгдээд байгаа юм. Тийм болохоор ингээд ер нь мэдээллийн технологийн салбарт хэчнээн юм зарцуулагдаж байна вэ гээд өмнө нь бас нэг судалгаа хийж байсан. Нийслэлийнх үлдчихсэн байсан. Ингээд энд хүснэгт ирүүлсэн. Энэ хүснэгт дээр нийлбэр дүнгээр 225 тэрбум төгрөгийн ажлыг сүүлийн 5 жил хийсэн байна. 225 тэрбумаасаа 137 тэрбум төгрөг нь улс, нийслэлийн төсөв, 88 тэрбум нь гадаадын зээл, тусламж. Ингээд 137 тэрбум төгрөгөөс 25 оных дээр 125 тэрбум байгаа. Тэгэхээр сүүлийн 1 жилд ерөөсөө дийлэнх нь байна гэсэн үг. Энэ сүүлийн 1 жил яагаад ийм 25 дээр нь яагаад ийм их өндөр тоо гарчхав гэдэг нэг асуулт.

Дараагаар нь камерын талаар л их ярилаа. Одоо ингээд 35 ажлын 16 нь камертай холбоотой байна. Камерын хяналт, камерын юу гээд. Тэгэхээр энэ камерууд дунд чинь үнэхээр ийм их камерын ажил бид нар хийгээд байна уу давхардсан юм яваад байна уу? 125 тэрбум төгрөгөөс чинь 137 тэрбум төгрөгөөс чинь энэ камерын юунууд нэлээн том дүн болох гээд байна шүү дээ. 35 ажлаас 16 нь. 176 уулзвар дээр 2606 камер суурилуулжээ. Одоо Дэлхийн банкны зээлээр 180-н байршил дээр хэдэн камер суурилуулах гэж байгаа юм бэ гэдэг асуулт. Тэгээд камерын засвар, үйлчилгээний баг шийдлийг ер нь яаж хийж байгаа вэ? Ер нь камер тавьчихаад тэгээд тэр чинь хугацаа нь дороо дуусчихдаг. Дахиад аваад тавиад байдаг ингээд зардал нэмэгдээд яваад байгаа асуудал байгаа. Энэ 2 дугаар асуулт камертай холбоотой.

Гуравдугаарх нь гадаадын зээл, тусламжийн 2, 3 дахь функт 15 сая доллар. Тэгээд энэ нийслэл улсын төсвөөр хийсэн жагсаалтын бас 2, 3, дээрээс нь 24, 25, 26 эд нар болохоор энэ уулзварын авто ухаалаг систем, камержуулах гээд агуулга нь адилхан юм харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр 80 тэрбум төгрөгөөр улс, нийслэлийн төсвөөр хийсэн ажил нэмэх нь 15 сая доллар буюу нийтдээ 110 тэрбум төгрөгийн утга агуулга ойролцоо төсөл харагдаад байна. Эд нарын хоорондын ялгааг хэлж өгөөч. 4-д нь.../минут дуусав./

Ч.Анар: Золжаргал гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Золжаргал: 4 дүгээрт нь Улаанбаатар хотын хөгжлийн корпорац хувийн эвсэлтэй хамтраад РР нөхцөлөөр ухаалаг зогсоолуудын төсөл хэрэгжүүлж байгаа юм. Яг ийм агуулгатай зүйл, ижил чиг үүрэгтэй зүйл 5.8 сая долларын төслийг гадаадын зээл, тусламж дээр тавьсан байна. Энийг лавлая.

Тэгээд түрүүн хэлсэн шүү дээ нөгөө нийт энэ 35 ажлын чинь 11 нь актлах зогсоох хэрэгтэй, 25-ыг нь үргэлжлүүлэх мөн үү Аудитын судалгаагаар нь тайлан гарч байгаа гээд энэ 11 дээр тайлбар хэлээдхээч. Уг нь энэ ирсэн нөгөө жагсаалтуудын дагуу л нэг нэгээр нь сонсчихмоор байгаа юм л даа. Тийм асуулт байна.

Түүний дараа өмчийн бүртгэл нийслэлийн хэмжээнд 1.5 тэрбум төгрөг. Энийг дотоод улсын хэмжээнд Төрийн өмчийн газар 750 сая төгрөгөөр иймэрхүү агуулгатай ажил хийсэн. Улсын хэмжээнд өмчийн бүртгэл дээр. Нийслэлийн энэ төсөл дээр болохоор 1.4 тэрбум байна. Тэгэхээр энэ ямар систем нь тийм нарийн

юм уу? Энэ зах зээлийн юунаас нь өмнөх жишгээс 2 дахин өндөр байгаад байна. Энэ дээр тайлбар. 100 хувь хийгээд дуусчихсан юм байна шүү дээ. Энэ дээр тайлбар хэлж өгөөч гэж.

30 минут 30 секунд. Тэгэхээр ийм байна. Umoney шилжүүлж авч байгаа юм байна. Тэр Umoney дотор чинь нөгөө карт дотор үлдчихсэн мөнгөнүүд байгаад байгаа юм. Яг баримттай тоо бол би хараагүй. Гэхдээ ирсэн мэдээллээр 30 тэрбум төгрөг байна гэж байгаа юм. Тэр картын мөнгө хаашаа орох вэ, юу болох вэ? Тэр дээр хийсэн үнэлгээ байгаа юу? Дараа нь нэг тодруулж болно тээ?

Ч.Анар: Хэн хариулах вэ? Мэдээлэл технологийн газрын дарга Түмэнбаяр.

Б.Түмэнбаяр: Түмэнбаяр асуултад хариулъя. Жагсаалтын 2, 3, 24, 25, 26 дээр давхардсан ажлууд байна уу ижил төстэй ажил нэршил байна гэдэг дээр тайлбар өгье. 20 онд БГД дээр, ХУД дээр анхны энэ камерын системүүдийн туршилт явагдсан юм. БГД дээр жишээ нь Модны 2, Төмөр замын уулзварын урд тал дээр 2 уулзвар дээр бүрэн тоноглоод ер нь энэ камерыг нутагшуулахад хэр боломжтой юм бэ Монголд нутагшуулах боломжтой юм уу гэдэг байдлаар туршилт явагдаад 4 уулзваруудыг тус тус ерөнхийдөө зохион байгуулаад ажилласан юм. ХУД дээр жишээ нь Нарны хороолол буюу МИС-ийн хажуу талын уулзвар дээр тухайн үедээ женетикийн тоног төхөөрөмжүүдийг тавиад яг энэ түрүүний хэлдэг 10 зөрчлөөс тухайн үедээ 5 зөрчил илрүүлээд ажиллаж байсан юм. Энэхүү 2 төсөл маань ерөнхийдөө үргэлжлээд өнөөдөр 176 уулзвар болоод ингээд явж байгаа юм.

180 байршил дээр нийтдээ хэдэн камер суурилуулах вэ одоогийн энэ камертай чинь давхцаж байгаа юу гэдэг. 180 байршил дээр одоо яг гүйцэтгэгч нь сонгон шалгаруулалт явж байна. Тухайн гүйцэтгэгч Дэлхийн банкны тендерт ирүүлсэн компани нь саналаараа тухайн 180 уулзваруудыг өөрсдийнхөө шийдлээр санал болго гэдэг байдлаар явчихсан. Эцсийн үр дүн гараагүй байгаа учраас аль компанийн яг хэдэн камер гэдэг байдлаараа тоо өгөх боломжгүй байна.

Засвар үйлчилгээний асуудал дээр хэрхэн, яаж шийдэж байгаа вэ гээд. Камеруудын засвар, үйлчилгээний ажил дээр бид нар 1 жилийн хугацаанд гүйцэтгэгч компани нь хариуцна. Жилийн дараа тухайн захиалагч байгууллага хариуцдаг байсан бол энэ жилээс дэд төвүүд цаашдаа хэв журмын камеруудын бүх ашиглалт, үйлчилгээг дүүрэг дүүргийн дэд төвүүд цаашдаа ашиглалт үйлчилгээг нь хариуцаж явна.

Өмчийн системийн хувьд гэх юм бол тухайн үедээ жилийн өмнө техникийн даалгавар анх гараад нийслэл дээр энэ өмчийн систем хийгдээд явж байхад улсын өмчийн систем бас сүүлд хойно нь гарсан юм байна лээ. Тэгээд нийслэл өмнө нь гэрээ байгуулагдаад хэрэгжүүлчихсэн учраас тэр чигтээ үргэлжлүүлээд явсан. Сүүлдээ юу гэж 2 байгууллага хоорондоо тохиролцсон гэхээр ямартай ч нийслэл нь нийслэл дээрээ явж байгаад хоорондоо интеграци хийгээд мэдээллээ солилцдог байдлаар ингэж хөгжүүлэе гэдэг байдлаар энэхүү систем нь цааш нь хөгжүүлэгдээд явж байгаа.

11 системийн хувьд. Ажиллахгүй байгаа 11 системийн хувьд энэ дээрээс тодорхой яг гарч ирээгүй байх шиг байна. Би нэрийг нь дурдаад өгөх юм бол 11 систем нь Нийслэлийн өргөдөл, гомдлын систем байна. Smart Ubcард аппликэйшн байна. Тохижилт үйлчилгээний автомашин GPS хяналтын систем суурилуулах гэдэг ажил байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад видео хурлын систем нэвтрүүлэх, Цахим газар өмчлөлийн онлайн систем, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд “eOffice” систем, ухаалаг төхөөрөмжид зориулсан цогц систем газар өмчлөлийн аппликэйшн, нийслэлийн хэмжээний СӨБ-ын хүүхдийн мэдээллийн санд суурилсан tsetserleg.mn, Ulaanbaatar.mn систем, нийслэлийн хэмжээний СӨБ-ын хүүхдүүдийн мэдээллийн санг үүсгэж эцэг, эхчүүдэд мэдээллээр хангах гар утасны аппликэйшн tsetserleg гэсэн ийм систем байна. Сүүлд нь эдгээр системүүд яг ашиглагдахгүй одоогийн байдлаар 11 систем аудит оруулаад актлуулах гэдэг ийм саналтай 11 систем байна. Бусад системүүдийн хувьд бүрэн ажиллаж байгаа. Цаашид ашиглаад явах ийм систем байна. Энэ жагсаалт дээр ороогүй байх шиг байна. Тийм.

Ч.Анар: Золжаргал гишүүний үлдсэн асуултад Замын хөдөлгөөний удирдлагын төвийн дарга Чулуунхүүгийн Хувьзаяа.

Ч.Хувьзаяа: Гишүүний асуултад хариу хэлье. Гишүүний асуусан асуулт 155 уулзвар дээр яг дата мэдээлэл цуглуулж байгаа камерууд одоо тээврийн ухаалаг систем дээр ашиглагдах уу эс үгүй бол давхардал үүсэхгүй биз дээ гэсэн асуулт асуулаа. Тэгж ойлгосон. Одоо суурилуулсан байх бүх камераас дата мэдээллийг авна. Ажлын даалгавартаа тусгачихсан тус систем нь камерын системээс дата аваад гэрэл дохиогоо өөрөө удирдах байдлаар зохицуулахаар ажлын даалгаварт тусгасан байгаа. Энэ төслийн хүрээнд Дэлхийн банкны төслөөр гол гудамж замын 8 чиглэлийн хөдөлгөөний урсгалыг 100 хувь хянаана.

Манай гэрэл дохионы удирдлагын тоног төхөөрөмж Солонгос улсын 2006 оны стандартаар үйлдвэрлэгдсэн хиймэл оюун ухаан болон өөрөө тооцоолох чадваргүй гэрэл дохионы угаалгын системтэй байдаг. Тэр гэрэл дохионы удирдлагын зам дээр байгаа тэр контроллер гэдэг тоног төхөөрөмжийг солино. 180 уулзвар буюу бүх уулзваруудынхыг. Иргэдэд гар утасны аппликэйшн болон зам дээр тавих 10 цэгт мэдээллийн самбар байршуулаад аль нөгөө 8 гол гудамж, замын аль замыг сонгож явах вэ гэдгийг харах боломжтойгоор байршуулж өгнө. 20 явган хүний ухаалаг гарц дээр хамгийн их хөдөлгөөний аюулгүй байдал алдагддаг явган хүний гарц дээр осол, аваар гардаг 20 байршилд ухаалаг гарц буюу сүлжээ тасарсан үед өөрөө өөрийгөө удирдаад явган зорчигч болон тээврийн хэрэгслээ мэдрээд ажиллах байдлаар гэрэл дохионы системийг шинэчилж байгаа гэсэн үг.

Ингэснээрээ хүний, одоо бол бид хэд камераа харж байгаад, хөдөлгөөний урсгалаа харж байгаад алианаас аль чиглэлд нь механик горимоор тэдэн секунд асаая, тэдэн секунд тойруулъя гэдгийг механикаар хийж байгаа. Энэ системийг нэвтрүүлснээр бүх замын дата өгөгдөлд нь тулгуурлаад 176 уулзвар нэг зэрэг тооцоолол хийгдээд бүгд автоматаар удирдах юм.

Зогсоолын системийн хувьд Нийслэлийн Засаг даргын захирамж Улаанбаатар хөгжлийн корпорац дээр хийгдэхээр сая 10 сард захирамж нь гараад Улаанбаатар хөгжлийн корпорацад нийслэлийн гудамж талбай, нийтийн эзэмшил дэх авто зогсоолыг гэрээгээр үйл ажиллагаа эрхлэхээр захирамж гараад тэндээс систем хөгжүүлэлт хийгдээд явж байгаа. Энэ “Тогтвортой авто зам, тээвэр” төсөл маань 2019 оноос хойш хэрэгжээд явж байсан. Одоо энэ системүүдийн давхцалыг арилгах үүднээс Төслийн удирдах хороог дахиад хуралдуулахлаар энэ саналууд дахиад яригдаад нэг талдаа гараад явна гэж бодож байна. Баярлалаа. Тийм.

Ч.Анар: Золжаргал гишүүн тодруулъя. Umoney-гийн талаарх, дансны үлдэгдлийн талаар орлогч дарга Амартүвшин.

А.Амартүвшин: Золжаргал гишүүний асуусан сүүлийн асуулт болох Umoney талаар хариулъя. Umoney энэ өөрөө үндсэн системийн өөрчлөлт гараагүй. Зөвхөн эзэмшигчийн шилжих өөрчлөлт гарсан болохоороо яг одоог хүртэл Umoney-г ашиглаад автобусандаа явах эрх нь нээлттэй байгаа. UBcard-ыг ч гэсэн ашиглаад явах эрхтэй байгаа. Мөн энэ дээр нийслэл дээр ирснээс интеграци хийгээд явах юм бол банкны картыг бас шууд уншуулаад бас автобусаар явдаг энийг нь нээчихсэн байгаа.

Тийм болохоор, хуучин Солонгосчуудтай гэрээ хийхэд заавал Umoney ашиглаж хийнэ гэдэг гэрээтэй байсан бол нийслэл авснаас хойш заавал UBcard ашиглах шаардлагагүй шууд банкны карт, эсвэл Umoney, эсвэл UBcard-ыг ингээд гурвууланг нь нэгэн зэрэг хаана ч ашиглаад явахаар боломжтой болгочихсон байгаа. Тэрнээс үлдэгдэл энэ тэр гэж байхгүй. Тэр систем нь өөрөө нэг байгаа болохоор зөвхөн л нэр нь солигдож байгаа. Систем нь өөрөө нэг байгаа болохоор үлдэгдэл байхгүйгээр явчхаж байгаа юм.

Ч.Анар: Индрийн микрофонд 1 минут.

А.Амартүвшин: Тухайн эзэмшигч нь өөрөө аппликэйшнтэйгээ холбосон бол тэрийгээ шилжүүлээд авах боломжтой. Аппликэйшн UB карт ч юм уу Umoney аппликэйшнтэйгээ холбоогүй зүгээр шууд ТҮЦ-ээс ч юм уу түгээх цэгээс худалдаж аваад 5 мянган төгрөг гээд нэг ашиглаад алдчихсан бол тэр recover хийх боломжгүй.

Ч.Анар: Золжаргал гишүүн тодруулах уу?

Ж.Золжаргал: Тэр ухаалаг зогсоолын асуудлыг төслийн даалгавар дээрээ давхцал байна уу үгүй юү гэдгийг дахиж check-лэж байж хэрэггүй бол үгүй болно. Хэрэгтэй бол нэмэх юм байна гэж ойлголоо.

Улсын хэмжээнд 750 сая төгрөгөөр төрийн өмчийнхөн өмчийн бүртгэлийн платформ хийсэн. Нийслэл дээр 1.4 байгаа. Энэ өндөр үнэтэй нь ямар учиртай юм гэдэг асуулт байна.

Саяын тэр юуны асуудал байна шүү дээ карт. Энэ карт дотор их мөнгө байна гээд нэг тоо гаргачхаад байгаа, тооцоо хийгээд байгаа юм л даа. Хаячихсан дахиж яах боломжгүй, нөгөө ухаалаг болоогүй байсан. Тэгэхээр тэр чинь бүртгэл хийчихсэн мөнгөн дүнгийн нэг ийм код байгаа. Тэрийг яаж гаргаж авч хэн эзэмших вэ гэдэг. Нийлбэр дүн нь нэлээн том л юм байгаад байна даа.

RFID маань юу боллоо? RFID tag 3 тэрбумаар?

Ч.Анар: Ажлын хэсгээс Мэдээлэл технологийн газрын Дэд бүтэц, техник хэлтсийн хяналтын дарга Түмэнбаяр.

Б.Түмэнбаяр: Гишүүний асуултад Түмэнбаяр хариулъя. Системийн зөрүүтэй асуудал гээд улсынх 725 сая төгрөгөөр нэгдсэн Нийслэл гээд. Энийг тухайн улсын системийн техникийн даалгаврыг нь би яг хараад мэдэхгүй байна. Тухайн системүүд дээр урьдчилсан ажлын хэсэг ажиллаад ойролцоо үнийг нь

тогтоогоод, тендер зарлаад, тендер дээр оролцогч компани нь үнээ тогтоогоод явдаг. Манай хувьд яг хэдэн модуль улс дээр хийгдээд, манай дээр хэдэн модуль нь зөрүүтэй байгааг яг тулгаж хараагүй болохоор сайн хэлж мэдэхгүй байна. Ямар ч байсан нийслэлийн хэмжээнд тендер зарлагдаад оролцогч компани үнээ шалгаруулаад гүйцэтгээд явсан байгаа.

Смарт картын төлбөрийн үлдэгдэл яг албан ёсоор тухайн үедээ Солонгос компани дээр явж байсан. Ойролцоогоор 3.5-4 тэрбум орчмын эзэнгүй картын буюу дансан дахь үлдэгдэл мөнгө байна гэж яригддаг. Яг.../минут дуусав./

Ч.Анар: 1 минут нэмж өгье индрийн микрофон.

Б.Түмэнбаяр: Яг албан ёсны тоог нь танд эргээд мэдэгдье.

RFID-гийн хувьд нийслэлийн хэмжээнд Зам, тээвэр хөгжлийн яамтай хамтраад тухайн үедээ Зам, тээврийн яам системийг нь хийнэ. Нийслэл нь дэд бүтцээ хариуц гээд тэгж байсан. Бид нар 2022 онд дэд бүтцээ хийсэн. Улаанбаатар хотын 156 уулзвар дээр бүх автомашины орц, гарц дээр RFID-ийн уншигч буюу tag reader-ийг бүгдийг нь суурилуулсан байгаа. Нийслэлийн хувьд дэд бүтцийнхээ асуудлыг хийсэн. Одоо Зам, тээврийн яаман дээр систем нь хөгжүүлэгдээд явж байгаа. Миний сүүлд сонссоноор тэнд системийн гүйцэтгэгч нь сонгон шалгаруулалт нь хийгдээд явж байна гэж сонссон.

Систем бүрэн гарч ирсэн тохиолдолд тоног төхөөрөмжүүд ажиллахад бэлэн байгаа. Хамтраад ингээд интеграци хийгээд ажиллахад ямар нэгэн асуудал байхгүй. Таг-ний хувьд 450 мянга орчим tag автомашинууд дээр суурилуулчихсан байгаа. Ялангуяа төрийн байгууллагын автомашинууд дээр tag-нууд бүрэн суурилуулчихсан. Таг-ний суурилуулалтын процесс 50.../минут дуусав./

Ч.Анар: Нэмж хариулах уу? Золжаргал гишүүн 2 дахь тодруулга.

Ж.Золжаргал: Түрүүн таны нөгөө хаагдсан 11 систем бол энэ дотор ороогүй юм байна шүү дээ. Энэ дотор байхгүй юм байна. Тэгэхээр тэр чинь тусдаа мөнгөн дүнтэй байх гээд байна. Тэр 11 хаагдсан системийн нийлбэр дүн нь хэдэн төгрөг байсан гэдэг асуулт.

Хоёрт нь би Амартүвшин даргаас Hotula апп-ын талаар асуух хэрэг байна. Энэ ингээд энэ хүн бол спортоор хичээллэдэг, дугуй унадаг, алхдаг их сайн хүн юм байна. Тэгээд тэр нь ингээд ногоон хүн учраас ногоон зээлийн санхүүжилт, хөнгөлөлттэй автобусанд хямдхан явдаг, автобусаар явдаг бол сайн хүн байна гээд ингэх гээд байна шүү дээ. Тэгээд жоохон залхуу хүн бас жоохон уучихдаг барьдаг иймэрхүү нөхдүүд яах юм? Муу хүн болох уу? Энэ дээр ийм юуны зөрчил гарахгүй юу? Тэр талаар нь эрх зүйн юун дээр та нар харсан л байх ялгаварлах асуудал. Нэг ийм асуулт.

2 дахь нь болохоор биометрикийн энэ камерын мэдээллүүд дээр хэрэглээнд эрх зүйн хязгаарлалт болоод төвөг болж байгаа асуудлууд тулгарч байна уу?

Ч.Анар: Индрийн микрофон дээрээс Амартүвшин дарга.

А.Амартүвшин: Hotula аппликэйшн дээр ашиглагдах ногоон онооны системийн журам нь яг төслийн байдлаар явагдаж байгаа. Ирэх оны 1 сарын

НИТХ-аар энэ төсөл маань орж танилцуулагдаж, тэгээд батлагдах байх гэж бодож байна. Одоогоор энэ өөрийнх нь үндсэн зорилго нь иргэдийг алхуулах, иргэдийг цааш нь дахиад нийтийн тээврийг ашиглах, дээрээс нь эрүүл зөв амьдрал руу чиглүүлэх, мөн хог хаягдлаа ангилан ялгах гээд нийслэлээс хийж байгаа арга хэмжээндээ уялдуулж иргэдээ ногоон онооны интеграциар ойлгуулах. Тэгэхгүй бол одоог хүртэл яадаг вэ гэх юм бол нийслэл ийм ажил хийж байна, тийм ажил хийж байна, ийм зам заслаа, ингэж тэглээ гээд л бид нар сошиалаар, телевизээр л сурталчилдаг бол одоо нийслэлээс хийж байгаа том ажлуудаа, нийслэлээс хийж байгаа ажлууд дээрээ иргэдийн оролцоо.../минут дуусав./

Ч.Анар: Индрийн микрофонд 1 минут нэмье.

А.Амартүвшин: Ингээд иргэдийн өөрийнх нь оролцоогоор нь нийслэлийн хийж байгаа нийгмийн сайн сайхны төлөө, нийгмийн хөгжлийн төлөө хийж байгаа ажил дээр иргэд нь өөрсдөө оролцоогоороо хийгдээд явчих ийм үндсэн том зорилгыг явж байгаа.

Тэр нь ингээд урамшууллын хэмжээтэйгээр иргэдийг илүү ногоон амьдрал руу чиглүүлэхэд юу гэх юм мотивац өгөх энэ чиглэлээр л явж байгаа. Тэрийгээ юу гэдэг юм гэр хороололд амьдарч байгаа айл өрхүүд маань тэрийгээ цуглуулж байгаад, зундаа цуглуулж байгаад нүүрс, түлээгээ тодорхой хэмжээний хямдралтай үнээр авдаг. Байшин айл өрхүүд маань тог дээрээ тодорхой хэмнэлттэй үзүүлдэг. Оюутан, залуучууд маань автобусныхаа мөнгөн дээрээ хэмнэлттэй үзүүлдэг иймэрхүү байдлаар ашиглалтад оруулахаар явж байгаа. Гол зорилго нь ерөнхийдөө мотивац өгөх.

Ч.Анар: Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Нийслэлийн төсвөөр хэрэгжиж байгаа технологийн салбарын төсвүүдтэй нь ерөнхийдөө бид нар танилцаж байгаа. Өмнө нь бас мэдээллээ өгье гэж байхад төсвүүд нь байхгүй байсан болохоор буцааж байсан. Одоо яг төсвүүдтэйгээ орж ирсэн байна. Энэ Улаанбаатар хотын Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн ашиглалт үйлчилгээ, нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем гээд UB-Engineering хөгжүүлэлт 24 онд хийж байгаа юм байна 2.5 тэрбум юм уу? Тэрбум төгрөгөөр энд UB-Engineering-гийн талаар хийж байгаа юм байна шүү дээ.

Тэгээд энэ 2040 Улаанбаатар хотын нэгдсэн төлөвлөгөө дээр болохоороо энэ Улаанбаатар хотын 2 дугаар хэлхээний нийт хэдэн километр байгаа юм бэ гэдэг тэр тоо байхгүй байсан. Би тэрийг асуугаад тэр байхгүй байгаа юм байж байж яаж 2040-ийн үндсэн төлөвлөгөөгөө та нар болчихсон гэж үзээд байгаа юм бэ? Тийм төлөвлөлт нь байхгүй юм байж байж яаж Улаанбаатар хотыг хангана гэж төсөөлж байгаа юм бэ гээд асууж байсан. Тэгтэл энэ нь болохоороо 2 жилийн турш 2.5 тэрбум төгрөгийг зарцуулаад явж байгаа ийм төсөл юм байна шүү дээ. Тэгэхээр энэ төслийн UB-Engineering-тэй холбоотой мэдээллийг авмаар байна.

Ерөнхийдөө энэ тайлангаас харахаар асар олон нэг ажлыг 2, 3 удаа давхар хийчихсэн харагдаад байна л даа. Энэ авто замын хяналтын камертай холбоотойгоор хэдэн ч удаа ажлууд хийгдчихсэн байгаад байгаа юм. Энийгээ бас тайлбарлаж өгөөч гэж хүсэж байна. Тэгээд би чинь нийслэлийнхнээс юм асуухаас айдаг болчихоод байна шүү дээ. Улаанбаатарын утаатай холбоотой Хятадаас

яагаад 300 тэрбумаар түлш авч байгаа юм бэ гээд л хэлсэн. 2 хоногийн дараа нь над руу чинь бүүр ингээд сэтгүүлч нар бөөндөө дайрлаа шүү дээ.

Тэгээд нийслэлээс байгаа гэдгийг нь сэтгүүлч нар ч хүртэл хэлж байлаа. Би энийг бас протоколд тэмдэглүүлээд л үлдээ л гэж бодож байна. Ер нь бас хэдүүлээ ингэж муухай улс төр бас хийдэг баймааргүй байна. Энэ чинь нөгөө нэг бодлогын л юм асууж байгаа. Тэрнээс биш хэн нэгэн хувь хүн рүү чиглэсэн ч байдаг юм уу асуудлуудыг гаргаагүй байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ бас жоохон хариуцлагатай ханддаг баймаар байна. Нийслэлийн төсвөөс бас юуг санхүүжүүлээд, юуг санхүүжүүлэхгүй байгаа юм гэдгийг нь бас ганц энэ технологийн зүйлийг ч биш бусад зүйлсийг бас бид нар харах ёстой юм болов уу л гэж би харж байна.

Ч.Анар: Амартүвшин дарга хариулах уу? Мэдээлэл технологийн газрын Техник хяналтын хэлтсийн дарга Түмэнбаяр.

Б.Түмэнбаяр: Гишүүний асуултад хариулъя Түмэнбаяр. UB-Engineering-тэй холбоотой сүүлийн 2, 3 жил ерөнхийдөө UB-Engineering систем Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хөгжүүлэлт нь хийгдэж явж байгаа. Эхний шат нь одоо 2 дахь бараг 3 дахь шат нь явагдаж байна. Инженерийн байгууламжтай холбоотой системийн хөгжүүлэлт нь хийгдчихсэн. Сая 12 сарын 20-ны Засаг даргын мэдээлэл технологийн албан хаагч нартай хийсэн уулзалтын үеэр танилцуулагдаж байгаа энэ танилцуулга дээр системийн ажиллагаа бүрэн хийгдсэн, инженерийн байгууламжийн мэдээллүүдээ гүйцэд оруулахгүй байна гэдэг ийм асуудал яригдсан.

Нөгөө талаар энэ байшин ашиглалт хүлээж авч байгаа ажлын хэсэгт нийслэлийн зүгээс ялангуяа энэ UB-Engineering-г заавал оруулсны дараа хүлээж авах шаардлагатай гэдэг ийм концепцыг оруулж өгье гэдэг байдлаар ерөнхийдөө ярилцаад системийн ажиллагаа бүрэн хийгдсэн. Байгууллагуудад бүх мэдээллүүдийг оруулах ийм ажлуудыг зохион байгуулъя гэдэг байдлаар ажиллаад явж байгаа.

Камеруудын ажлын давхцалыг тайлбарлах гээд. Байгууллагууд маань ихэнхдээ камеруудын ажлыг ерөнхий нэршлээрээ өгөөд байгаа. Тухайн төсөлтэй холбогдолтой ч юм уу детальчилж өгөхгүй шууд дүүргээрээ ч юм уу эсвэл байгууллагын нэг чиглэлээрээ зүгээр хяналтын камер ч гэдэг юм уу ингэж явагдаад ер нь жил жилд давхардалтай харагдаад байгаа юм.

Цаашдаа бид нар юу яаж байна гэхээр энэ яг зорилт буюу тухайн чиглэсэн ажлынх нь нэршлээр нь нэрлэж байгаач. Зүгээр нэг камер ч юм уу ерөнхий байдлаар ингээд битгий нэрлээч гэж, нэршил өгч байгаач гэдэг байдлаар яваад байгаа юм. Тэгээд камерын нэршлийг ч юм уу дүүргүүдээр байнга ерөнхийдөө жил дээр нь нэршлээ юу гэдэг юм Хан-Уул дээр 2 төсөл хэрэгжлээ гэхээр л Хан-Уул дүүргийн камержуулалт, эсвэл тохижилтын камержуулалт гэдэг юм уу ийм ерөнхий нэршил яваад байна. Яг деталь нэршил яваач гэдэг байдлаар харвал давхардал харьцангуй бага харагдана гэж бодож байна. Хариулж дууслаа.

Ч.Анар: Цэнгүүн гишүүн тодруулъя.

С.Цэнгүүн: Тэгээд энэ UB-Engineering-гийнхэн 2 жилийн хугацаанд ажиллаад үр дүн нь гараагүй байхад 2040 дээрээ бас бид нар энэ нэгдсэн тоог нь

бас оруулж чадаагүй юм байна шүү дээ тээ? Тэгэхээр чинь энэ 2040 чинь яг газар доорх инженерингийн байгууламжийн тухай нэгдсэн дата оруулаагүйгээр явж байгаа юм байна тийм үү нийслэлээс?

Ч.Анар: Индрийн микрофон 1 минут.

Б.Түмэнбаяр: Систем дээр ганц тулгарч байгаа асуудал бол түрүүний хэлдэг зарим нэг байгууллагууд нь мэдээллийн сан нь цахим байхад орчхоод байгаа юм. Ихэнхдээ цаасан мэдээллүүдийг мэдээллийн санд оруулахад жаахан ажиллагаа явагдаж байгаа. Тэгэхдээ харьцангуй бид нар байгаа мэдээллүүдийг ерөнхийдөө оруулаад явж байгаа. Энэ жил магадгүй яг энэ жил бүрэн дуусаагүй байна. Сая 12 сарын 20 гэхэд системийнхээ танилцуулгуудыг Батзориг даргад Засаг дарга хэлсэн. Бүх системүүдээ танилцуулгуудыг оруулаад ямархуу бүтэцтэй байж байгаа юм, танилцуул гэдэг ийм чиглэл өгөгдчихсөн байгаа. Яг ямар мэдээлэл нь хэдий хугацаанд гэдгийг би сайн яг цээжээрээ мэдэхгүй байна. Би танд эргүүлээд Захирагчийн ажлын албанаас яг энэ дулааны шугам сүлжээ, усны сүлжээ энэ тэр яг хэдэн хувьтай аль аль байгууллагын мэдээлэл оруулсан гэдэг мэдээллийг нь танд хүргүүлбэ.

Ч.Анар: Надад асуух асуулт маш их байна. Тэгэхдээ гол асуултаа асуучихъя. Камержуулалт нийслэл мэдээлэл технологийн хөгжил дээр бас нэлээн идэвхтэй урагшаа явж байгааг нь дурдах ёстой. Гэхдээ энэ камерууд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцээгүй байгаа. Чиг үүргийн байгууллага нь зөвлөмж өгсөн. Биелүүлдэггүй. Дахиад энэ дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүд дээрээ мэргэжлийн яамнаасаа зөвлөмж авах хуультай. Тэн дээрээ бас нэлээн олон санал, гомдлууд байдаг.

Тэгэхээрээ цаашаа ухаалаг хот хүссэн, хүсээгүй бид нар ухаалаг хот болж хөгжинө. Тэгэхээрээ маш их камерыг тавьж байгаа. Өндөр хөгжсөн улсууд мэдээллийн аюулгүй байдал дээр маш их онцгой анхаардаг. Тэгээд үнэхээр яагаад анхаарч байгаа юм бэ гэхээр Монгол Улсын нэн эмзэг мэдээллүүдийг алдахгүй гэдэг. Үзээрэй. Энэ дээр үндсэндээ аюулгүй байдлын стандарт маш ноцтойгоор зөрчигдөөд явж байгаа. Үүн дээрээ ямар арга хэмжээ цаашдаа авах вэ? Энэ 2 зөвлөмжийг зөрчсөн камеруудыг худалдан авсаар байх вэ? Яах вэ бодит нөхцөл байдлыг нь ойлгож л байна л даа.

2 дугаарт нөгөө түрүүн Золжаргал гишүүн ч ярьж байна И-монгол гэж байгаа, Hotula-гэж байгаа Umoney, одоо UBCard энэ сүүлдээ сошиал платформ хийнэ гэж байна. Төрийн мэдээлэл, төрийн албан хаагчид, төрийн шийдвэр гаргагч нарын түвшинд үндэсний нэгдсэн мэдээллийн сүлжээ байхгүй болохоор “viber” ашиглаж байгаа асуудал үнэн. Гэхдээ энийг хариуцаж хийх ёстой газар нь нийслэл мөн үү? Энэ нь ямар зөвлөмж, ямар санал санаачилга хэзээ гарсан ямар байгууллагын шийдвэрээр энэ явж байгаа юм бэ? Энд нийслэлийн чиг үүрэгт хамаарагдахгүй санагдаад байх юм.

Дахиад бид ТӨК-удаа цөөлөөд төрийг цомхон бүтээмжтэй болгохоор явж байтал нөгөө талд нь эргээд төр өөрөө цахим хэлбэрт маш олон хувийн хэвшлийн ч юм уу онц шаардлагагүй үйлчилгээнүүдийг хийх гээд байгаа юм биш үү. Тэн дээр ялангуяа манай нийслэл Улаанбаатар хот маань манлайлалтай явах гээд байна уу даа гэсэн болгоомжлол байна. Тэгэхээр үүний цаана маш олон том худалдан авалтууд явж байна. Тэгэхээр энэ 3 асуултыг асууя.

Амартүвшин дарга хариулах уу?

А.Амартүвшин: Анар гишүүний асуултад хариулъя. Камерын зөвлөмжүүдийг бид нар яам болон Тагнуулын газраасаа чиглэлийг аваад танилцуулаад яам болон чиг Тагнуулын газраас тодорхой брэндийн тэр дундаа Орос, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэсэн тэнд ашиглагддаг сервер болон тийм камеруудыг ерөнхийдөө хориглодог. Тийм болохоор гуравдагч орны камер болон тийм системүүдийг авч ашиглаж ороорой гэдэг байгаа. Бид нар тодорхой хэмжээний тендер зарлахдаа камерын системүүд авахад дандаа Тагнуулын газарт тэрийг хянуулдаг. Тагнуулын газраас ерөнхийдөө зөвшөөрөөд энд ийм ийм брэндийнх болно, ийм ийм компанийнх болно, ийм ийм компанийнх хориотой, болохгүй гэдэг тэр зөвлөмжийг нь авч байгаад худалдан авахаа зарлаж энэ ажлуудыг хийгээд явдаг.

Мөн мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар гэх юм бол бид нар Хууль зүй, дотоод хэргийн яам болон мөн Тагнуулын газартай яг энэ дээр нь ажилладаг. Энэ дээр ганц камержилт гэхгүйгээр Тагнуулын газартай бид нар нүүрснийхээ асуудал дээр ч гэсэн тестээ хамт хийдэг. Тагнуулын газар яг хэрэглэж байгаа иргэдээс хэрэглэж байгаа нүүрсийг шатааж байна уу, тестэлж байна уу, үзэж байна уу гэдгийг хүртэл тавьж шалгадаг байгаа. Тийм болохоор яг энэ 2 асуудал дээр тагнуулын байгууллагатай бараг 7 хоног болгон бид нар хамт ингэж ажиллаж явдаг.

Сошиал платформ нь зөвхөн нийслэлийн хэмжээнд бид нар одоогийн байдлаар хэрэгжүүлээд нийслэлээс хэрэгжүүлж байгаа ажил, нийслэлээс хэрэгжүүлж байгаа энэ бүх мэдээ, мэдээллийг нэгдсэн том шугамаар хэрэгжүүлж гээд явж байгаа. Цаад том харж байгаа юм нь бүхэл бүтэн Америкт сервертэй Америкт байгаа Фэйсбүүк ч гэдэг юм уу эдгээр компаниуд нь бид нар мэдээллээ цацахын тулд бид нар жил болгон хэдэн 100 сая долларыг зарцуулдаг гэдэг бол манай Монголын зах зээлээс гараад Америкийн зах зээл рүү энэ ордог мөнгө. Энэ мөнгийг ерөнхийдөө бид нар нийслэлдээ, Монгол Улсдаа эргэлдүүлэх энэ том зорилгыг тавьж энэ платформыг яг энэ Фэйсбүүктэй адилхан хэрэглэдэг ийм платформыг оруулж хэрэглэе гэж байгаа. Энэ зөвхөн яг одоогийн байдлаар нийслэл дээр нийслэлийн иргэдэд зориулагдсан платформ байгаа. Тэрнээс хөдөө орон нутгийнхан яг энэ дээр хэрэгжилт ороогүй явж байгаа.

Энэ цаашлаад улсын хэмжээнд хэрэгжүүлнэ, улсын хэмжээний платформыг явъя гэх юм бол холбогдох яамдаас нь зөвшөөрөл аваад энийг хэрэгжүүлээд явна. Яг одоогийн байдлаар зөвхөн нийслэлд ногоон оноотой нүүрстэйгээ Hotula системтэйгээ ингээд холбогдоод энэ платформ хийгээд явж байгаа. Ерөнхийдөө сошиал платформ болон дээрээс нь бүх мөнгө төгрөгийн үйлчилгээ байдаг. Нийслэлээс үзүүлж байгаа автобусны үйлчилгээ, UBCard гээд л энэ бүгдийг интеграци хийчихсэн ийм системийг ороод явна.

Дээрээс нь иргэд маань тодорхой хэмжээний гудамжинд явж байгаад эвдрэлтэй зам харгуй, гэрэл нь шатчихсан гаднах гэрэлтүүлгийн энэ систем байгаа шүү дээ. Ингэх юм бол шууд зургийг нь аваад тэр энэ Hotula платформ дээр тавьчихна. Тэгэх юм бол тэр нь өөрөө location-той учраас тэр газрыг нь олоод энэ мэдээ, мэдээллийг шууд ингэж хурдан явдаг, солилцдог ийм системийг оруулж ирж байгаа. Тэгэхгүй одоо гэх юм бол тухайн хэсгийн ахлагч нь мэдээллээ цуглуулаад хороон дээрээ нэгтгэдэг. Нэгтгэчихсэн мэдээг цаашаа дүүрэг дээрээ нэгтгэдэг. Дүүрэг дээрээ нэгтгээд нийслэл дээр байгаад нөгөө засвар, үйлчилгээ,

мөн maintenance гэдэг энэ бүх ажлыг хийж явдаг. Тийм болохоор дор хаяж хамгийн багадаа бид нар сараас 2 сарын хугацааны дараа засвар, үйлчилгээ нь орж явдаг. Энийг хэрвээ системдээ ингээд явчих юм бол бид нар дор хаяж л сараас сар хагасын хугацаа яагаад 14 хоногийн хугацаанд бүх энэ эвдрэл, зам, үйлчилгээний ажлыг хийж явна гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Ингээд мэдээлэл бол шууд нэгдсэн системээр ирдэг. Нэгдсэн систем ирээд шууд хариуцаж байгаа хүн дээр нь шууд очдог. Одоо бид нар өргөдөл, гомдлын систем хариуцаж байгаа хүн дээр очдогтой адилхан бид нар зураг авлаа ингээд ороод явдаг. Яг нөгөө 102 системтэй адилхан гэсэн үг. Нөгөө замын.../минут дуусав./

Ч.Анар: Тэгэхээр чиг үүргийн байгууллага болоод нөгөө чиг үүргийн яамны 2 зөвлөмжийн дагуу мэдээллийн технологийн дэд бүтэц, шийдлүүд хийгдэх ёстой. Та өөрөө сая бас дурдаж байна л даа. Энэ протоколд үлдэж байгаа болохоор. Тэгэхээр яг энэ зөвлөмжүүдийг дагаж байгаа юу? Би албан ёсоор тодруулахад бол өөр л зүйл яриад байна лээ. Тэгэхээр үүн дээрээ та яг үнэхээр зөвлөмжийн 2 чиг үүргийн байгууллагын зөвлөмжийг ягштал нь биелүүлж дагаж байгаа гэдэг надад тодорхойлолтыг эсвэл гаргаж өгөх хэрэгтэй байх юм. Тийм бичгээр болон амаар. Энэ дээр протоколд үлдэж байгаа болохоор. Би болохоороо бас аль газар нь үнэн ярьж байгааг тодруулах шаардлагатай болж байх шиг байна.

2 дугаарт тэр ерөнхийдөө нийслэлийн үйлчилгээ цахимжиж байгаа бол маш сайн, сайшаалтай, хурдацтай явж байгаа. Тэр дээр эргэлзэх зүйл байхгүй. Гэхдээ энэ аюулгүй байдлын чиглэлээр үндэсний аюулгүй байдлын хэмжээний мэдээлэл солилцооны системийг хийх ёстой гэдгийг зарчмын хувьд дэмжиж байгаа ч гэсэн энийг бодлого гаргаж хийх ёстой газар нийслэл мөн үү гэдгийг л би асуугаад байгаа юм. Тийм. Тэгэхээр энд хаана шийдвэр гаргах ёстой юмыг та хэд маань үнэхээр бодит болж байгаа юмаа хаана шийдвэр гаргаад хийгээд байгаа юм бэ? Энэ хоёр дээр тодруулга протокол дээр авъя.

Амартүвшин дарга.

А.Амартүвшин: Нийслэл Улаанбаатар хотын зүгээс эдгээр 2 хууль тогтоомж болон зөвлөмжүүдийг зөрчөөгүй явж байгаа. Энэ дээр яг манай хуулийн газар ажиллаад тодорхой хэмжээний хуульд өөрчлөлт оруулах хэдэн зүйлүүд байгаа. Эд нарыг төслийг нь боловсруулаад Засгийн газарт 2 төслийг боловсруулаад өргөн барьсан байгаа. Засгийн газар дээр одоо яг Засгийн газрын гишүүдээс санал авагдаад явагдана. Тэгээд ирэх 7 хоногийн Засгийн газрын хурлаар зарим асуудлууд нь орох байх. Орсноор Их Хуралд өргөн баригдах байх. Энэ яг хууль дээр өөрчлөлтүүд орох ёстой байгаа 6 зүйл байгаа юм. Энэ зүйлүүд дээр ороод явах байх. Ингээд Засгийн газраас энэ хуулийг батлаад явна.

Кибер аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал 2 дээр. Яг ийм ийм системийг ингээд манай улсад ингээд ашиглах нь зүйтэй гэдэг ерөнхий зөвлөмжийг бас Засгийн газраас гаргуулья гэсэн явж байгаа. Тэгэхгүй бол байнга нэг.../минут дуусав./

Ч.Анар: Индрийн микрофонд 1 минут.

А.Амартүвшин: Нэг ажлыг гүйцэтгэх болгондоо эсвэл нэг тендер зарлах болгондоо бид нар яам болон Тагнуулын газраас тодорхойлолт авдаг. Тэр

тодорхойлолт нь тухайн жил болгоноосоо заримдаа өөр өөр ирдэг. Дараа нь нөгөө интеграци хийхээр нөгөө брэндүүдийнх нь хооронд бас уялдаа холбоо нь байхгүй, систем нь хоорондоо таарч өгдөггүй гэдэг асуудлууд заримдаа гардаг. Тийм болохоор яг үндсэн Засгийн газрын нэг тийм чиглэл авъя. Яг манай Монгол Улсынх бол камерын хяналт дээрээ цаашлаад платформ дээрээ яг ийм ийм кибер аюулгүй байдлыг хангасан ийм сервер дээр ажилладаг гэсэн ийм зориулалтуудыг авах байх. Ямар ч байсан сайдад танилцуулагдсан байгаа. Сайдаас удахгүй дараа 7 хоногийн Засгийн газрын хурлаар танилцуулагдана гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа.

Ч.Анар: Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулж Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Золжаргал гишүүнээр тасалъя. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Энэ мэдээлэлтэй ерөнхийд нь танилцаад энэ дээр ер нь энэ аливаа системийн худалдан авалт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргаж байгаа асуудал дээр нэлээн сайн судалгаа хийх ёстой байх гэж бодож байна. Ялангуяа сая жишээлбэл Нийслэл өмчийн бүртгэл дээр гээд 1.5 тэрбум төгрөг зарцуулж байхад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 750 сая төгрөгөөр яг адилхан систем аваад шинэчлээд улсын хэмжээнд дуусаж байна гэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь бид нар хоорондоо ямар уялдаа холбоогүй ажиллаж байгааг л харуулж байгаа юм. Нийслэлийн төсөв гэж байхгүй шүү дээ. Адилхан л улсын төсөв.

Тийм учраас энэ аливаа систем худалдан авах судалгаан дээрээ хариуцсан чиглэлийн яамнаасаа бас нэлээн мэдээлэл авч солилцож байж энэ системийг авах шаардлагатай юу үгүй юу гэдэг дээрээ шийдвэрээ гаргаж энэ засаглалаа сайжруулах шаардлагатай байна гэж харж байна.

Хоёрт болохоор 2026 оны төсөв яг боловсруулагдаад бас явж байгаа. Шийдвэрүүд гарч байгаа байх. Тэр дээрээ бас энэ давхардсан юмнууд хийгдээд байгаа юм биш биз дээ гэдгийг энийг эргэж хянах ёстой байх л гэж хэлмээр байна.

Гуравт, 80 тэрбум төгрөгөөр ингээд камержуулалтын ажил хийж байгаа юм. Тэгэхдээ камержуулалт маань нөгөө талдаа ингээд бодоод үзэхээр программ хангамж нь, дэд бүтэц нь, камерынх нь зардал ороод л болж байгаа байх л даа. Тэгэхдээ 1 камерт оногдож байгаа зардал нь 2600 камер гээд бодоод үзэхээр ойролцоогоор 30 сая төгрөгийн өртөгтэй болж байна л даа. Тэгтэл тэр камерыг ашиглаад та бүхний олж байгаа торгуулийн орлого чинь хэд билээ? Эдийн засгийн хувьд яг ингээд бүх цэг болгон дээр тэгж камер тавиад үнэхээр ашиг байсан уу үгүй юу эд нар гээд бас тэр тооцооллуудаа цаана нь сайн боддог байх л гэж бодож байгаа. Тийм учраас ер нь нөгөө энэ аливаа энэ системийн худалдан авалтын захиалга өгч байгаа юман дээр энэ эдийн засгийн тооцоо юмнуудаа сайн харж байгаа биз дээ. Энэ дээр нь бас сайн эргэж харж хянаж байх ёстой юм байна даа л гэсэн ийм зөвлөмж л хэлмээр байна даа.

Ч.Анар: Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Нэлээн сайн мэдээлэл авлаа. Ер нь энэ зорилго нь нэг талаасаа жил болгон төсөв тооцоо хийдэг мэдээллийн технологи, инновац дээрээ юунд анхаарах вэ гэдгийг бид нар мэдэж байх ёстой. Шүүмжлэхдээ биш эсрэгээрээ мэдээллийн технологи болон кибер аюулгүй байдал гэдэг зардлын ангилал хүртэл Монгол Улсад байгаагүй. Түрүүчийн удаа бид нар Байнгын хороон дээр санал тавьж байгаад Сангийн яаман дээр зардлын ангилал оруулж өгсөн. Тэгэхээр цаашдаа яг тодорхой зардалтай юман дээр хэрэгцээтэй юмаа, зайлшгүй хэрэгцээтэй юмаа ингээд төсөвтөө оруулаад явах нь зөв гэж бодож байгаа юм.

Дахиад нэг дүгнээд хэлэхэд энэ ийм байна. Бид нар ингээд мэдээлэл авлаа та бүхнээс. Тэгэхээр энэ мэдээллийн 5 жилийн 225 тэрбум төгрөгийн мэдээллийн технологийн худалдан авалт хийжээ. Үүнээс талаас илүү нь сүүлийн 1 жил байна. Өөрөөр хэлбэл, зардал огцом өсөж байгаа юм. Огцом өсөж байгаа учраас анхаарах шаардлага байна. Энэ дотор нь акталсан 11 төсөл ороогүй байна. 11 төслийг нуугаагүй байлгүй. Орхигдуулсан байх. Улсын Их Хурлын бүтцийн байгууллагаас албан бичгээр авч байгаа мэдээлэлд орхигдуулж болохгүй шүү гэдгийг анхааруулж хэлье. Тэгээд нийлбэр дүнгээ ингээд бодоод үзэхээр хяналт тавих шаардлага байна. Бид нар ингээд эргүүлээд хараад ярихад давхардсан байж болзошгүй асуудлууд байна. Хэрэгжиж эхлээгүй зардал нь гараагүй төслүүд байна.

Тэгэхээр өмнө нь хийгдчихсэн том дүнтэй төсөлдөө хэрэгжих гэж байгаа төслийн агуулга нэг байх юм бол тэндээс юун дээр нь зардлаа хэмнэх вэ гэдэг асуудлуудад ярьж болохоор юм байна. Энэ хяналтыг улсын төсөв ч байна, нийслэлийн төсөв ч байгаа. Тэгэхээр НИТХ дээр бас төсвөө та бүхэн ярилцаж байгаа тэндээ бас тавиад явж байгаа, тавьж байх ёстой ИТХ дээр хяналт тавихад нэг асуудал байгааг би сөхөж ярьсан. Түрүүний ярьдаг шиг асуудал ярихаар Золжаргал хүмүүжилгүй хүн шүү гэдэг ийм хариултыг олон нийтийн сүлжээгээр авмааргүй байна. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчид маань хяналтаа тавихын тулд хангалттай цалинтай баймаар байна. Бас иргэдээс сонгогдсон хүмүүс, төлөөлөгч нар иргэдтэйгээ очоод уулзахад ажил зардал гарна. Тийм төсөв, мөнгөтэй байх ёстой.

Тэгээд цалин байхгүй, төсөв байхгүй гэсэн мөртөө бүгдээрээ нэг нэг компанийн захирал болгоод төрийн өмчийн компанийн захирал болгоод тавьчихсан. Тэр нь тэгээд тэр олон хүн дотор юм хусдаг хүн ч байгаа, мөн сайхан ажилладаг ч хүн байгаа эд нарыг тэгээд л хэл амтай нэг юм яваад байдаг. Авах ёстой цалин хөлсөө аваад, хийх ёстой ажлаа хийгээд тэр төрийн өмчийн компаниудаас нь холдуулахгүй бол яаж төсөв батлах юм. Манай найз энэ компанийн захирал, би нөгөө үйлчилгээний газрын захирал тэгээд бүгдээрээ нэг захирал болохоор чинь нөхдийнхөө юмыг бодъё, ажлаа бодъё, хэрүүл маргаан яах вэ, улс төржихгүй гээд бүгдийг нь сайхан баталж өгөөд тэрний нэг хэсэг чинь энэ мэдээллийн технологи бас явж байгаа шүү дээ ИТ. Тэгэхээр иймэрхүү энэ салбар ч гэлтгүй ер нь хяналтаа сайжруулахын тулд бас тийм зүйл хийх шаардлагатай юм байна гэдэг асуудлыг бас нэг сөхөж тавимаар байна. Энэ дээр бас ажиллаж байгаа хүмүүс бас байгаа юм байна лээ. Баярлалаа.

Ч.Анар: Энэ мэдээллийн технологийн аюулгүй байдал гэдэг дэлхий нийтийн томоохон бараг тэргүүлэх сэдэв болж байгаа. Тэгэхээр сая хуулийн өөрчлөлтийн талаар ярьж байна. Би өөрөө Кибер аюулгүй байдлын хуулийн ажлын хэсгийг ахлаад Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр ажлын хэсгээ ахалж байгаа. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бас өөрчлөгдөж байгаа.

Тэгэхээр энэ дэлхий нийтээрээ энэ мэдээллийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдалтай цахим технологи, мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар илүү анхаарал хандуулж байгаа. Тэгэхээр мэдээж үр ашигтай хямдхан байх, интеграцитай байх гэдэг бодит практик шаардлагыг маш сайн ойлгож байгаа юм.

Гэхдээ ямар ч хурд, үнэнээс илүү үндэстний язгуур эрх ашиг гэж байх ёстой. Тэгэхээр Монгол хүн Монгол Улсын дэд бүтэц, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдал, иргэний аюулгүй байдал гэдэг бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд байх ёстой. Тэгэхээр тэр язгуур эрх ашиг бол ямар ч төсөвт өртөг, хурдтай ажил хийхээс дээр бий, илүү тавигдана гэдгийг хэлье.

2 дугаарт сая хоёр ч гишүүн маань дурдлаа. Нийслэл дээр Монгол Улсын Их Хурал болоод Монгол Улсын Их Хурлын гишүүд хууль тогтоох болон Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй. Тэгэхээр тэр чиг үүрэг, шаардлага хяналт тавьсны төлөө ялангуяа нийслэлийнх нь зүгээс улс төрийн акц хийж байна гэж ярьж байна. Тэгэхээр эдгээр үг хэлсэн асуудлуудыг бас нухацтай бодож аль аль талдаа хариуцлагатай байж анхаарч ажиллаасай гэж хүсье. Тэгэхээр та бүхэнд баярлалаа.

Их Хурлын гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Инновац цахим бодлого, хөгжлийн дэд хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байгааг мэдэгдэж байна. Идэвхтэй оролцсон ажлын хэсгийн гишүүд болон Их Хурлын гишүүдэд баярлалаа.

16.51 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР